

ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ *Иргэдэд зориулсан гарын авлага* **ХАНГАХ НЬ**



Засгын газрын
Хэрэг эрхлэх газар

“Орон нутгийн Засаглалыг
дэмжих хөтөлбөр” төсөл



Mongolia

ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

Иргэдэд зориулсан гарын авлага

Боловсруулсан: *Л.Лувсанжамц*
Г.Пүрэвтогтох
Д.Норовсамбуу
Г.Гантөгс

Улаанбаатар хот
2011 он

Орон нутгийн Засаглалыг дэмжих төсөл

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 11-р байр, 606 тоот
Утас: 976-11-264565
Вэб хуудас: <http://www.lgsp.mn>

© Орон нутгийн Засаглалыг дэмжих хөтөлбөр төсөл. 2011

ОНЗДХ төслийн зөвшөөрөлгүйгээр энэхүү номыг хэсэгчлэн буюу бүтнээр нь дахин хэвлэхийг хориглоно.

“Орон нутгийн засаглалд иргэдийн оролцоог хангах нь”

Иргэдэд зориулсан гарын авлага

Агуулга

<i>Товчилсон үгсийн жагсаалт</i>	7
<i>Өмнөх үг</i>	8
<i>Хураангуй</i>	10
<i>Нэгдүгээр бүлэг. Орон нутгийн засаглал дахь иргэдийн оролцоо</i>	11
<i>1.1 Орон нутгийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулахад иргэдийн оролцоо</i>	14
<i>1.2. Иргэдийн оролцоог хангах хэлэлцүүлгийн арга</i>	16
<i>Хоёрдугаар бүлэг. Иргэдийн оролцоо бүхий хяналт</i>	27
<i>2.1 Яагаад иргэдийн оролцоо бүхий хяналт хэрэгтэй вэ?</i>	28
<i>2.2 Үр дүнтэй хяналт хийх нь</i>	30
<i>Ашигласан материалын жагсаалт</i>	38
<i>Хавсралт</i>	39

Товчилсон үгсийн жагсаалт

ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
ИНХ	<i>Иргэдийн нийтийн хурал</i>
ЗД	<i>Засаг дарга</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
ОНХЗ	<i>Олон нийтийн хяналтын зөвлөл</i>
ОНЗДХ	<i>Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр төсөл</i>
НҮБХХ	<i>Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр</i>
ТБУСТХ	<i>Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль</i>



Өмнөх үг

ЗГХЭГ-ын дэргэдэх, НҮБХХ-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр” (ОНЗДХ) төсөл нь 2007 оноос Баян-Өлгий, Говь-Алтай, Хэнтий, Төв аймгуудад, 2009 оноос Дундговь аймагт хэрэгжиж, төвлөрлийг сааруулах бодлогын туршилтыг явуулаад байна.

Төслийн зорилго нь нутгийн удирдлагын байгууллагын чадавхийг бэхжүүлэх замаар орон нутгийн үйлчилгээг сайжруулах, төвлөрлийг сааруулах, төв болон орон нутгийн засаглал хоорондын чиг үүрэг, эрх мэдлийн зохистой хуваарилалт, төсвийн шинэчлэлийн асуудлаар бодлогын зөвлөгөө өгөх ажил юм. Төслийг хэрэгжүүлэх үндсэн зарчим нь иргэдийн оролцоонд суурилсан бөгөөд орон нутгийн үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээний чанарт хяналт тавих үйл явцад туршилтын аймгууд нь иргэдийн оролцоог хангаж ажиллах чадварт суралцаж байна.

Өнгөрсөн хугацаанд эдгээр аймгууд нь иргэдийн хэлэлцүүлгийг баг, сумдадаа зохион байгуулж, орон нутгийн хэрэгцээт нийтийн үйлчилгээний чиглэлийг уг хэлэлцүүлгээр тодорхойлж, гарсан саналыг нь сүм, аймгийн ИТХ-аар хэлэлцэн шийдвэрлэж, төсөл хэлбэрээр санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

Төслийг НҮБХХ, туршилтын аймгийн төсвөөс хамтран санхүүжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд таван аймагт нийт 242 төслийг хөдөө аж ахуй, хүн амын ундны усны хангамжийг сайжруулах, хог хаягдлыг зайлуулах, нийтийн ахуйн үйлчилгээ, бизнесийн дэд бүтэц, хүн амын мэдээллийн үйлчилгээг сайжруулах, хот, орчны тохижилт, гудамж талбайг гэрэлтүүлэх чиглэлээр хэрэгжүүлэв.

Түүнчлэн, аймгийн ИТХ нь төслийн хэрэгжилтэд хяналт тавихдаа иргэдийн оролцоо бүхий хяналтын механизмыг бий болгон олон нийтийн хяналтын зөвлөлийг сумдад байгуулж, төслийн хэрэгжилтэд хяналт тавьснаар эдгээр төслүүд амжилттай хэрэгжих үндэс болж байна. Нутгийн удирдлагын байгууллага нь иргэдийн оролцоог хангаж ажиллаж сурснаар, тэдний иргэдэд ил тод, нээлттэй байх, иргэдийн өмнө хүлээх хариуцлага нэмэгдсэн. Үүний үр дүнд төрийн үйлчилгээний чанар сайжирч, орон нутагт ардчилал бэхжих, мянганы хөгжлийн зорилтод хүрэх үйл явцад нутгийн удирдлагын байгууллага хувь нэмрээ оруулж байна. Өөрөөр хэлбэл төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах нь дан ганц төв Засгийн байгууллагын төвлөрүүлэн эрхлэх зүйл бус, орон нутгийн удирдлагын байгууллага, ард иргэдийн шууд оролцоонд суурилах зарчмаар хэрэгжүүлэх нь илүү үр нөлөө, үр ашигтай, ил тод, ардчилсан болох нь бидний туршлагаас харагдаж байна.

Иймд төвлөрлийг сааруулах бодлогын туршилтын хүрсэн амжилт, туршлагыг бусад аймагт нэвтрүүлэх, иргэдийн хэлэлцүүлгийн ач холбогдол, иргэдийн оролцоо бүхий хяналтын үр дүнг олон нийтэд таниулах зорилгоор тус гарын авлагыг ОНЗДХ төсөл эмхэтгэн хэвлүүлж байна. Энэ гарын авлагыг орон нутгийн хөгжлийн төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх үүрэг бүхий нутгийн удирдлагын байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, иргэдийн хэрэгцээнд зориулан бүтээв.

Уг гарын авлага нь та бүхний мэдлэг, оюунд тодорхой хувь нэмрийг оруулж, ажилд тань тус дэм болно гэдэгт найдаж байна. Номыг сайжруулах, шинэ санаа оноо нэмэхийг хүсвэл бидний зүгээс талархан хүлээн авах болно.

ТӨСЛИЙН ҮНДЭСНИЙ МЕНЕЖЕР
Л.ЛУВСАНЖАМЦ

Хураангуй

Тус ном нь төрийн болон орон нутгийн үйлчилгээ, улсын болон орон нутгийн төсвөөр хийгдэх ажлыг төлөвлөх, үйлчилгээний чанар, хэрэгжилтэд хяналт тавихад иргэд хэрхэн оролцох, засаглалд иргэд оролцсоноор ямар үр дүн гарах, иргэдийн оролцооны талаарх мэдлэг нэмэгдэх, иргэд чадавхижснаар нутгийн удирдлагын байгууллагын хариуцлага сайжруулах зэрэг асуудлыг авч үзэж байна.

Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах, орон нутгийн үйлчилгээг төлөвлөхөд иргэдийг зохион байгуулж оролцуулах нь нутгийн удирдлагын байгууллагын үүрэг юм. Гэвч ихэнхи нутгийн удирдлагын байгууллага нь иргэдийг хэрхэн зохион байгуулж оролцуулах аргачлалыг мэдэхгүйгээс тэр бүр иргэдийн оролцоог хангаж ажиллахгүй байна. Энэ зорилгын үүднээс тус гарын авлага нь орон нутгийн хөгжлийг төлөвлөх үүрэг бүхий нутгийн удирдлагын байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдэд иргэдийн оролцоог хангах арга замууд, үүний дотроос хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулах, иргэдийн оролцоо бүхий хяналтын механизмыг хэрхэн бий болгох зэрэг аргачлалыг “Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр” төслийн туршлагад үндэслэн толилуулж байна.

Номын 1-р бүлэгт, засаглал дахь иргэдийн оролцоо хэр чухал болох, орон нутгийн үйлчилгээг төлөвлөхөд иргэд хэрхэн оролцох, иргэдийн хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулах талаар өгүүлнэ.


2-р бүлэгт иргэд орон нутгийн аливаа ажил үйлчилгээ, хөрөнгө оруулалт, төсвийн зарцуулалт зэрэгт хяналт хэрхэн тавих, нутгийн удирдлагын байгууллага нь иргэдийн оролцоо бүхий хяналтыг хэрхэн бий болгох тухай өгүүлсэн болно.

Гарын авлагад ОНЗДХ төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулах аргачлал, олон нийтийн хяналтын зөвлөлийн хяналтын маягыг хавсаргав.

Нэгдүгээр бүлэг

Орон нутгийн засаглал дахь иргэдийн оролцоо

Хүн төрөлхтний ардчилсан нийгмээс олсон нэг том амжилт бол иргэд төрийн засаглалыг байгуулж, түүнд оролцох боломжтой болсон явдал юм. Гэхдээ иргэд энэ боломжоо бүрэн дүүрэн ашиглаж, ахуй амьдралаа сайжруулж, эрхээ эдэлж чадаж байна уу гэсэн асуудал гарна. Ихэнхи иргэд дөрвөн жилд нэг удаа УИХ болон орон нутгийн сонгуульд оролцож, төлөөлөгчид сонгох төдийгөөр уг боломжоо хязгаарлаж байна. Зарим иргэн төрөөс үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнгийн талаар гомдол, саналаа зохих байгууллагад гаргадаг. Гэхдээ ганц нэгээрээ гаргасан гомдол санал эзэндээ хүрэхгүй, салхинд хийссэн мэт замхарч, асуудал шийдэгдэхгүй байсаар байх нь олонтаа.



Таны амьдарч буй сумд халуун ус байхгүй, зам нь эвдэрсэн, ногоон байгууламж үгүй зэрэгт та бухимддаг уу? Яагаад би ийм орчинд амьдрах ёстой юм бэ? Таны сонгосон төлөөлөгч, төрийн байгууллага (үг асуудлыг хариуцсан) үүнийг яагаад шийдэхгүй байна вэ? Манай хөршүүд таны адил санаа нь зовж байгаа болов уу? Гэх мэт асуултууд тулгарч байгаа бол та орон нутгийнхаа хөгжил, ахуй амьдралыг сайжруулахад өөрийн хувь нэмрийг оруулах хэрэгцээ шаардлага бий болжээ. Гэхдээ засаглалд оролцоход учир бий. Иргэн таны хувьд хамгийн түрүүнд оролцох ёстой, тантай хамгийн ойр оршиж, асуудлыг шуурхай шийдвэрлэж чадах засаглал бол нутгийн удирдлагын байгууллага буюу аймаг, сумын ИТХ, Засаг дарга, түүний Тамгын газар, болон баг, хорооны ИНХ, Засаг дарга байдаг. Гэвч нутгийн удирдлагын байгууллагын хариуцан хийх ёстой ажлыг та шүүрэн авч, гардан гүйцэтгэхийг оролцоо гэхгүй.

Орон нутгийн засаглалд иргэд оролцох нь зөвхөн дөрвөн жилд нэг удаа болох сонгуульд саналаа өгөх, эсвэл ямар нэгэн албан байгууллага, албан тушаалтанд гомдол саналаа хүргүүлээд, тэдний шийдвэрийг хүлээн суухыг хэлэхгүй. Иргэдийн оролцоо гэдэг нь хүлээж суух бус, аливаа асуудлыг шийдвэрлэхэд дуу хоолой өөрийн санал, бодлоо нэмэрлэх, хийж бүтээх, идэвхитэй хяналт тавих үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл таны амьдарч буй сумд сургуулийн барилга барих зайлшгүй шаардлага бий бол ямар загвартай барилга, хаана барих, хэнээр бариулах, ямар хөрөнгө ашиглах зэрэгт өөрийн санал, бодлоо нэмэрлэх болон чанартай барьж байгаа эсэхэд үнэлгээ өгөх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулахад хувь нэмрээ оруулна гэсэн үг.

Мэдээж тухайн орон нутагт тулгамдаж буй **асуудлыг шийдвэрлэх нь дан ганц таны, эсвэл орон нутгийн удирдлагын байгууллагын хүчин чармайлтаас шалтгаалах зүйл биш** гэдгийг юун түрүүнд санаж нь зүйтэй. Иргэний хувьд уг асуудал нь ямар дэс дарааллаар, хэрхэн явагддаг болон иргэн, нутгийн удирдлагын байгууллагын үүрэг оролцоо нь чухам ямар хэсэгт нь байх вэ гэдгийг сайн ойлгож оролцвол амжилтанд хүрнэ. Өөрөөр хэлбэл таны оролцох ёстой ажил байх боловч, мөн таны оролцоо шаардлагагүй, засаглалын болон мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх ажил бас бий гэдгийг ойлгох ёстой.

*... Авто замын эвдрэлд
бухимдсан иргэн Б...
Улаанбаатар хотын
Баянзүрх дүүргийн
нутагт байдаг Сансарын
Туннелийн замыг
хувиасаа 1 сая төгрөг
гарган засав...*

*Эх үүсвэр: 2008 оны 10
сарын 05 өдрийн
Телевизийн мэдээллийн
хөтөлбөрөөс*

*Иргэдийн оролцоо бол
“Иргэд ахуй амьдралдаа
нөлөөлөх үйц эдийн засаг,
нийгэм, соёл, улс төрийн
үйл явцад оролцох үйл
ажиллагаа” юм.*

*Эх үүсвэр: 1993 оны
НҮБХХ-ийн
“Хүний хөгжлийн
илтгэл”*



Зураг 1. Орон нутгийн засаглал дахь иргэдийн оролцоо

Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд иргэд орон нутгийн үйлчилгээний төлөвлөлтөд оролцох болон орон нутгийн үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг хоёр үндсэн хүрээнд оролцож болох юм.

Өөрөөр хэлбэл иргэн та ямар орон нутгийн үйлчилгээ авах хэрэгцээ байгааг тодорхойлох, үйлчилгээг бодит ажил болгох ямар боломж, нөхцөл байгаа талаар саналаа хэлэх, мөн тухайн ажлыг хэрэгжүүлэх явцад хяналт тавих, засч залруулах, энэ бүхний эцэст асуудал үнэхээр шийдэгдсэн эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөхөд таны оролцоо маш чухал юм. Түүнчлэн уг асуудлыг шийдэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг бий болгох, ажлыг чанартай хийж гүйцэтгэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг нь нутгийн удирдлагын байгууллагын хариуцан гүйцэтгэх ажил боловч энэ хүрээнд иргэн та оролцох боломж бүрэн байдаг. Гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулахад иргэд оролцох нь хуулиар нээлттэй зүйл юм.

Тухайн орон нутгийн иргэдийн ашиг сонирхолыг хөндсөн аливаа асуудлыг шийдвэрлэхээр нутгийн удирдлагын байгууллагаас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг орон нутгийн үйлчилгээ гэж ойлгоно.

Жишээлбэл:

- Авто зам, гүүр барих болон засварлах
- Халуун усны байр, сургууль цэцэрлэгийн байр барих болон засварлах
- Худаг ус гаргах болон хамгаалах
- Хадлангийн талбайг хашиж хамгаалах
- Цэцэрлэгт хүрээлэн байгуулах гэх мэт

1.1 Орон нутгийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулахад иргэдийн оролцоо

Орон нутгийн үйлчилгээг төлөвлөх гэдгийг иргэн зөвхөн хувийн ашиг сонирхолоо нутгийн удирдлагын байгууллагад уламжлан, шийдвэрлүүлэх үйл ажиллагаа гэж хялбаршуулан ойлгох нь өрөөсгөл талтай. Жишээлбэл, таны амьдарч буй газар халуун усны байр барих зайлшгүй шаардлага бий бөгөөд үүнийг өөрийн хашааны ойр барих нь танд чирэгдэлгүй байх болно. Гэтэл таны хөрш болон зэргэлдээ гудамжны хүмүүс бас тань шиг бодолтой байж болохыг та санах хэрэгтэй. Мөн таны хашааны зэргэлдээ барих нь орон нутагт мөрдөгдөж буй эрүүл ахуйн дүрэм журамтай хэр нийцэх, цэвэр усаа хаанаас тээвэрлэж зөөх болон орон нутгийн удирдлагын байгууллагаас хэрэгжүүлж буй бусад үйл ажиллагаатай хэр зохицож байна вэ гэдгийг нягтлах шаардлага гарна. Иймд төрийн зүгээс таны авахыг хүсч буй үйлчилгээг хүртээмжтэй, чанартай байлгахын тулд зөвхөн таны саналаас гадна бусад хүмүүсийн санал бодлыг бас харгалзах шаардлагатай.



Түүнчлэн иргэн аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчөөр дамжуулан санал бодлоо илэрхийлж, үйлчилгээний төлөвлөлтөнд оролцож болдог¹, гэвч энэ нь зарим тохиолдолд үр дүн багатай байдаг. Иймээс иргэд өөрийн хэрэгцээг бүрэн хангасан, чанартай ажил үйлчилгээг авахын тулд бусадтайгаа санал бодлоо хуваалцах, зөвшилцөх зайлшгүй шаардлагатай юм. Уг зөвшилцөлд иргэд “хэлэлцүүлэг” зохион байгуулж, оролцох замаар хүрэх боломжтой болно².

Шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцсоноор орон нутгийн удирдлага нь иргэдэд илүү ил тод, нээлттэй, хариуцлагатай болж ингэснээр төрийн үйлчилгээний чанар дээшилдэг. Жишээлбэл, 2010 онд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумд нийтийн цэцэрлэгт хүрээлэн байгуулагдсан байна. Анх цэцэрлэгт хүрээлэн байгуулах асуудлыг иргэдийн хэлэлцүүлгийн дүнд шийдвэрлэсэн бөгөөд хэлэлцүүлгийн үеэр өөр бусад чухал санал ч гарч байсан. Нээлттэй хэлэлцүүлгийн дүнд асуудлыг шийдвэрлэсэн тул цэцэрлэгт хүрээлэн байгуулах нь орон нутагт хийгдэх ажлуудын хамгийн эхнийх нь бөгөөд цаашид бусад чухал саналуудыг ажил хэрэг болгох юм гэдгийг иргэд ойлгож, сумын Засаг дарга болон гүйцэтгэгч компаний үйл ажиллагаанд хүлээцтэй хандаж байв. Мөн дээрх хэлэлцүүлгийн үеэр сумын ИТХ-н зүгээс баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар иргэдэд мэдээлэл түгээж, санал бодлоо хуваалцах боломжтой болсон юм. Нэгэнт иргэд санал хүсэлтээ гаргаж хэлэлцүүлэг зохион байгуулсан учраас цэцэрлэгт хүрээлэнгийн арчлалт, хамгаалалтын тал дээр иргэдийн хандах хандлага өөрчлөгдөж байв.

Орон нутагт хэрэгцээт ажил үйлчилгээг төлөвлөж, зохион байгуулах нь зөвхөн нутгийн удирдлагын байгууллага шийдэх асуудал хараахан биш, зөвхөн иргэний дангаар гаргасан шийдвэрийг үндэслэл болгодоггүй байна. Өөрөөр хэлбэл орон нутгийн үйлчилгээг төлөвлөх үйл явц нь **иргэн та болон танай хөршүүд, нутаг усныхан, нутгийн удирдлагын байгууллагын зөвшилцөл, хэлэлцүүлэгт үндэслэх хамтын шийдвэр** юм.

Иргэдийн оролцоо бүхий төлөвлөлт гэж юу вэ? ...Энэ бол иргэд орон нутагт тулгамдаж буй асуудлаа өөрсдийн оролцоотойгоор тодорхойлох, төлөвлөх үйл явц юм...

К.Томас (Андра Прабеш мужийн Засаглалын төвийн судлаач, Энэтхэг)

1. Энэ бол орон нутгийн засаглалд оролцох иргэдийн шууд бус оролцооны хэлбэр юм.
2. Хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох нь орон нутгийн засаглалд оролцох иргэдийн оролцооны шууд хэлбэр болно.

Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах дараах арга замууд байж болно. *Үүнд:*

- Баг, хороодын иргэдийн нийтийн хуралд оролцох
- Иргэдтэй уулзаж, санал солилцох
- Бичгээр санал, хүсэлт хүлээж авах
- Хэвлэл мэдээллээр орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг танилцуулах
- Оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх
- Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах
- Санал, асуулга явуулах
- Нутгийн удирдлагын байгууллагаас ажиглалт хийх
- Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах

Гэхдээ эдгээрээс хамгийн үр нөлөө бүхий арга зам бол нутгийн удирдлагын байгууллагаас хэрэгцээт ажил, үйлчилгээг төлөвлөхөд чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулж явуулах юм.

1.2. Иргэдийн оролцоог хангах хэлэлцүүлгийн арга

Монголчуудын зүйр үгэнд “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй...” гэсэн үг байдаг. Иргэд санал бодлоо солилцож, хэлэлцэж хүрсэн шийдвэр нь хамгийн оновчтой нь байх юм. Иргэдийн хэлэлцүүлгийн зорилго нь орон нутгийн хөгжлийн аливаа асуудлыг төлөвлөх, хянах, дүгнэх зэрэгт иргэдийн саналыг авахад оршино. Орон нутгийн хөгжлийн дараах асуудлуудыг хэлэлцүүлгээр хэлэлцэж болно. *Үүнд:*

- *Орон нутгийн үйлчилгээг төлөвлөх.* Жишээлбэл, сумын ИТХ, Засаг дарга түүний Тамгын газраас иргэдэд үзүүлэх орон нутгийн үйлчилгээнүүд (ТБУСТХ-ын 52.2-т заасан үйлчилгээний чиглэлүүд) халуун усны барилгын засвар, хог хаягдлыг бууруулах ажил, орон нутгийн зам засвар, гэрэлтүүлэг, олон нийтийн мэдээллийн төв гэх мэт үйлчилгээний чиглэлийг төлөвлөх.

- *Орон нутгийн урт болон дунд хугацааны хөгжлийн чиглэлийг тодорхойлох.* Хөгжлийн чиглэлийг иргэдийн хэлэлцүүлгээр сонгох, иргэдийн саналыг авах.

- *Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын чиглэл.* Жишээлбэл, Танай сумд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ямар ажлыг хийвэл зохих эсэхийг тодорхойлох (тухайн жилд сургуулийн барилгын засварын ажил, эмнэлгийн барилгын засварын ажлын аль илүү чухал, нэн тэргүүний хэрэгцээтэй эсэхийг иргэдийн хэлэлцүүлгээр шийдэх). Мөн хөрөнгө оруулалтын ажлын явцыг хянах.

- *Олон улсын байгууллага/төсөл, хөтөлбөрийн орон нутагт хэрэгжүүлэх ажлын чиглэл.* Жишээлбэл, Тогтвортой амьжиргаа-II төсөл, бусад төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр танай сумд хэрэгжүүлэх төслийн чиглэлийг сонгох.

- *Ядуурлыг бууруулах талаар хийгдэх ажлын чиглэлийг тодорхойлох.*
- *Байгаль орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны чиглэл.*
- *Орон нутгийн дэд бүтцийн асуудал.* Жишээлбэл, орон нутгийн зам, гүүр, цахилгаан, дулааны хөрөнгө оруулалт, засварын ажлыг хаана хэрхэн хийхийг иргэдийн хэлэлцүүлгээр шийдэх зэргийг тодорхойлох.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумд ОНЗДХ төслийн зохион байгуулсан нэгэн хэлэлцүүлгийн үр дүнг доорх жишээгээр үзүүлэв.

Хэлэлцүүлгийн зорилго: ОНЗДХ төслийн Хэнтий аймгийн Жаргалтхаан сумд 2011 онд хэрэгжүүлэх төслийн чиглэлийг сонгох

Хэлэлцүүлгийг зохион байгуулагч: Хэнтий аймгийн ИТХ, НҮБХХ-ийн ОНЗДХ төсөл
Оролцогчид: Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын 5-р багийн иргэд, сумын ИТХ-ын төлөөлөл, Хэнтий аймгийн ОНЗДХ төслийн менежер Р.Даваацэрэн

Хугацаа, байршил: 2011 оны 2-р сарын 22-ны өдрийн 11 цаг, Жаргалтхаан сумын ЗДТГ-ын байр

Хэлэлцүүлгийн үйл явц:

- **Хэлэлцүүлгийн бэлтгэл хангах:** Хэлэлцүүлгийн хугацаа нь Жаргалтхаан сумын 1-р улирлын багийн ИНХ явагдах хуваарийн дагуу 2011 оны 2-р сарын 22-нд зохион байгуулагдав. Хэлэлцүүлэгт оролцогчдод Хэнтий аймгийн ОНЗДХ төслийн менежер Р.Даваацэрэн төслийн танилцуулга, үйл ажиллагааны чиглэл, хэлэлцэх асуудал, хэлэлцүүлэг явуулах удирдамжийг танилцуулав. Мөн төслийн санхүүжүүлж болох үйлчилгээний чиглэл болон хориглох чиглэлийг танилцуулав.

- **Хэлэлцүүлгийг зохион байгуулж явуулах:** Хэлэлцүүлэгт оролцогчдын олонхий саналаар хэлэлцүүлгийн идэвхижүүлэгчээр сумын ИТХ-ын дарга н.Цогтбат томилогдов. Идэвхижүүлэгч хэлэлцүүлэгт оролцогчдыг 3 баг болгон хувааж, баг бүрээс саналыг танилцуулах болон саналыг тэмдэглэж авах хүн тус бүрийг сонгов. Баг тус бүр нийт 15-20 минут харилцан ярилцаж, багийн гишүүн бүрээс гарсан санал бүрийг дэлгэц цаасан дээр бичиж, нийтэд дэлгэн харуулав. Үүний дараа баг тус бүрээс гарсан саналыг багийн гишүүн 1-2 хүн нийтэд танилцуулав.

- **Хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэх:** Бүх саналууд танилцуулсны дараа төслийн хориглох зүйлд заасан санал байгааг оролцогчдоор тодорхойлуулж, жагсаалтаас хасав. Ижил төстэй саналыг нэгтгэн тоог саналын ард тавив. Багуудаас гарсан жагсаалтаас хамгийн чухал нь аль төсөл болохыг нийт оролцогчдоос санал авсаны дараа иргэд асуусны үндсэн дээрдараах 3 санал дээр иргэд санал нэгдэв. Үүнд:

1. Орон нутгийн телевиз байгуулах -15 санал
2. Интернэтийн антентай болох- 22
3. Насанд хүрэгчдэд боловсрол олгох танхимтай болох -28 санал

Санал тус бүрийг идэвхижүүлэгч оролцогчдоор хэлэлцүүлэн санал хураахад хамгийн олон саналыг “Насанд хүрэгчдэд боловсрол олгох танхимтай болох” санал авч 28 саналаар тэргүүлжээ.

Үр дүн: Хэлэлцүүлэгт оролцогчдын олонхийн саналаар “Насанд хүрэгчдэд зориулсан боловсрол олгох танхим”-ыг ОНЗДХ төслийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэхээр болсон байна.

Хэлэлцүүлгийг хэн зохион байгуулах вэ?

Хэлэлцүүлгийг зохион байгуулах нь нутгийн удирдлагын байгууллагын хариуцах ёстой үүрэг болох тухай дээр дурьдсан билээ. Гэхдээ тухайн үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн байгууллагаас зохион байгуулж явуулж болох талтай. Хэлэлцүүлэгт оролцогчдын санал бодлыг нэгтгэн, үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэхийн тулд дадлага туршлагатай идэвхижүүлэгч зайлшгүй хэрэгтэй болдог.

Хэлэлцүүлгийг орон нутгийн аливаа хөгжлийн асуудлыг төлөвлөх зорилгоор аймаг, сум, баг, хорооны ИТХ, Засаг дарга, Засгийн газар, яамд, мэргэжлийн агентлагууд (ГХХБТ-ийн газар гэх мэт), олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд, иргэд хэлэлцүүлгийг зохион байгуулж болно. Хэлэлцүүлгийн идэвхижүүлэгч нь хэлэлцүүлэг зохион байгуулах мэдлэг, дадлага туршлагатай байх ёстой бөгөөд үүнийг тусгай сургалтаар олж авдаг. Иймээс орон нутагт иргэдийн хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулахын тулд хэлэлцүүлэг идэвхижүүлэгчдийг урьдчилан сургаж, бэлтгэх хэрэгтэй юм.

Юуны түрүүнд зохион байгуулагч хэлэлцүүлгийн байр, хэлэлцүүлэг хийх цаг хугацааг урьдчилан товлож хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангана. Үүний дараа иргэдийг цуглуулах ажлыг зохион байгуулж, хэлэлцүүлгийг явуулна. Хэлэлцүүлгийг явуулах аргачлалыг зохион байгуулагч тал сонгож, хэлэлцүүлэг явуулах идэвхижүүлэгчийг сургаж, дадлагажуулсан байна. Хэлэлцүүлгээс гарсан саналыг зохион байгуулагч тал өөрийн үйл ажиллагаа, шийдвэртээ тусгах эсвэл холбогдох байгууллагад уламжлах ажлыг гүйцэтгэнэ.

Орон нутгийн үйлчилгээг төлөвлөхөд иргэдийн оролцоог хангах нь ямар ач холбогдолтой вэ?

- *Орон нутагт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох од суралцах - ингэснээр иргэд чадавхижих;*
- *Иргэд идэвхитэй төлөвлөгч болсноор төлөвлөсөн ажил үйлчилгээ, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд идэвхитэй хяналт тавигч болох;*
- *Иргэд идэвхитэй хяналт хийснээр үйлчилгээний чанар, тухайн ажлын гүйцэтгэл, чанар сайжрах;*
- *Иргэд нутгийн удирдлагын байгууллагатай идэвхитэй хамтран ажилласнаар иргэд-орон нутгийн байгууллагын харилцаа сайжрах;*
- *Орон нутгийн байгууллагадаа итгэх итгэл үнэмшил, үнэлэмж дээшлэх;*
- *Тухайн орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадсанаар иргэдийн орон нутагтаа амьдрах идэвхи, сонирхол нэмэгдэх;*
- *Орон нутгаас төв рүү шилжих, шилжилт хөдөлгөөн багасах;*
- *Иргэдийн амьдралын чанар сайжрах;*

Хэлэлцүүлгийг зохион байгуулж явуулахад анхаарвал зохих дөрвөн үндсэн үе шат байна.



Бэлтгэл үе шат



Зураг2. Орон нутгийн үйлчилгээг төлөвлөхөд иргэдийн оролцоог хангах үе шатууд



А. Хэлэлцэх асуудлын үндсэн чиглэл, мэдээллийг олон нийтэд түгээх буюу бэлтгэл үе шат.

***Зорилго:** Хэлэлцэх асуудлын үндсэн чиглэлийг орон нутгийн нийт иргэдэд нээлттэй мэдээлэх*

Энэ шатанд хэлэлцүүлгийг зохион байгуулагч оролцогчдод урьдчилан мэдээлэл хүргүүлсэн байна. Мэдээлэлд хэлэлцүүлэг хийх гэж буй зорилго, хэлэлцэх асуудлын хүрээ, хэлэлцүүлгийг зохион байгуулах байгууллагын танилцуулга, хэлэлцүүлэг болох он, сар, өдөр, цаг, явуулах байрыг тодорхой бэлтгэнэ. Мэдээллийг аль болох иргэд олж үзэх боломжтой газар байрлуулах, иргэдийн үзэж, сонсож болох мэдээллийн хэрэгслээр дамжуулна. Жишээлбэл, Говь-Алтай аймгийн ИТХ нь сумдад иргэдийн хэлэлцүүлэг хийх тухай мэдээллийг хэлэлцүүлэг явагдахаас 2 долоо хоногийн өмнө, сумдын ИТХ, ЗДТГ-т албан

Говь-Алтай аймгийн ИТХ нь ОНЗДХ төслийн хэлэлцүүлгийг 2011 оны 02-р сарын 24-нд Шарга сумын 1-р баг дээр багийн ИНХ-тай хамтран зохион байгуулах тул иргэд та бүхэн 24-ний өдрийн 11 цагт ЗДТГ-ын хурлын зааланд цугларна уу. Хурлаар ОНЗДХ төслийн 2011 онд Шарга сумд хэрэгжих төслийн чиглэлийг хэлэлцэнэ. Иймд иргэд та бүхэн өргөнөөр оролцоно уу.

“Алтай” радиогийн мэдээлэл:

бичгээр мэдэгдэн, багийн ИНХ-ын 1-р улирлын хуваарьтай давхцуулан зохион байгуулдаг байна. Говь-Алтай аймгийн ОНЗДХ төслийн ажилтан төслийн тухай танилцуулгыг урьдчилан сумдад хүргүүлж, орон нутгийн “Алтай” радиогоор иргэдэд мэдээлэл хүргэдэг байна.

ОНЗДХ төслөөс зохион байгуулах иргэдийн хэлэлцүүлгийн бэлтгэл үе шатанд доорх зүйлсийг ханган ажилладаг байна. Багийн иргэдийн нийтийн хуралд оролцогчдод хэлэлцүүлгийн дэг, журмыг танилцуулна. Иргэдэд ОНЗДХ төслийн үйл ажиллагааг товчхон танилцуулна.

Төслийн үйл ажиллагааны танилцуулгыг төслийн орон нутаг дахь идэвхижүүлэгч хэвлэмэл байдлаар хүргүүлсэн байна. Иргэдэд төслийн хөрөнгөөр санхүүжүүлж болох болон хориглох үйл ажиллагааны чиглэлүүдийг томоор бичиж, хэлэлцүүлгийн явцад ашиглахаар бэлдэнэ. Орон нутагт аймаг, сум, багийн ИТХ, Засаг даргын хариуцан хүргэх үйлчилгээг танилцуулна. Иргэдээс авах саналыг нэгтгэхэд ашиглахаар цаас болон бичгийн хэрэгслийг төслийн орон нутаг дахь менежерээс авч бэлдэнэ. Иргэдээс авах асуулгыг оролцогчдын тоогоор хувиалан олшруулна.

Анхаарах зүйлс:

- *Хэлэлцүүлгийг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, микрофон, зөөврийн компьютер, проектор, иргэдийн саналыг нэгтгэхэд ашиглахаар дэлгэц цаас болон бичгийн хэрэгсэл зэргийг бэлгэсэн байна.*
- *Хэлэлцүүлгийн идэвхижүүлэгчийн урьдчилан сургаж, дадлагажуулсан байх.*
- *Иргэдийн хувьд хэлэлцүүлэгт идэвхитэй оролцохын тулд өөрсдийн бичсэн саналаа цаасаар авчирч болно.*
- *Хэлэлцүүлгийг зохион байгуулагч тал хэлэлцүүлэгт зориулсан байраа урьдчилан бэлдсэн байх.*
- *Хэлэлцэх асуудлын үндсэн чиглэл, ерөнхий мэдээллийг түгээхэд ямар мэдээллийн эх үүсвэр ашиглахаа зөв сонгох. Жишээлбэл, орон нутгийн сонин хэвлэл, радио, телевиз, үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, зарлалын самбар гэх мэт. Мөн баг хорооны ИНХ дээр дараагийн удаад хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг түгээж ч болох юм. Эх үүсвэрээ сонгохдоо хэн ямар эх үүсвэрээс мэдээлэл авдаг вэ? гэдгийг тооцож үзэх нь хамгийн чухал байдаг.*
- *Зарыг хэлэлцүүлэг явуулахаас хамгийн багадаа 14 хоноогоос өмнө түгээх.*



Б. Хоёрдох үндсэн алхам бол хэлэлцүүлэгт оролцогчдыг бүрдүүлэх.

Зорилго: *Хэлэлцүүлгийн үр дүнд бодитой байлгахын тулд оролцогч талуудын ашиг сонирхолын тэнцвэрийг хангах*

Уг алхмаар хэлэлцүүлэгт оролцогчдыг бүртгэнэ. Хэлэлцүүлэг нь нээлттэй хэлбэрээр явагдах, аль болох олон хүний саналыг авах зорилготой учир иргэдэд оролцох боломж нь чөлөөтэй байх ёстой. Хэлэлцүүлгийн үр дүнд шийдвэр гарах ёстой учраас зарим тохиолдолд оролцогчдын санал зөрчилдөх, хуваагдах байдал тохиолдож болно. Ийм

нөхцөлд хэлэлцүүлгийн төгсгөлд шийдэх асуудлын хувилбарууд дээр санал хураалт явуулах шаардлага гардаг бөгөөд оролцогч талуудын ашиг сонирхолыг бүрэн илэрхийлэхэд оролцогчдын тэнцвэрийг хангасан байх нь маш чухал байдаг. Иймээс зохион байгуулагчид нь оролцогчдыг бүртгэхдээ ямар асуудал хэлэлцэж байгаагаасаа шалтгаалан оролцогч талуудын тэнцвэрийг хангах шалгуур үзүүлэлтүүдийг гаргасан байх ёстой байдаг. Жишээлбэл, хэлэлцүүлэгт оролцогч төрийн албан хаагчийн тоо иргэдийн тооноос ихгүй байх, иргэдийн төлөөлөл нь хэлэлцүүлэгт оролцогч төрийн албан хаагчийн шууд удирдлагад ажилладаггүй байх, хэлэлцэх асуудалтай холбоотой мэргэжлийн инженерийн төлөөлөл заавал байх гэх мэт.

Мөн зарим нэгэн асуудалыг хэлэлцэхэд мэргэжлийн байгууллагын төлөөллийг зайлшгүй байлцуулах шаардлага гардаг. Жишээлбэл, Авто зам барих чиглэлийг иргэд, захиргааны байгууллагын төлөөлөл зөвшилцөөд гаргасан байхад, замын инженерүүд уг чиглэлийн дагуу цэвдэг ихтэй, авто зам барих боломжгүй гэсэн дүгнэлт хийж болох юм.

Анхаарах зүйл:

- *Хэлэлцүүлгээр олон санал гаргуулахын тулд эрх ашиг нь хөндөгдөж буй талуудын төлөөллийг аль болох бүрэн хамруулахыг хичээх хэрэгтэй. Иргэд, төрийн бус байгууллага, Төрийн албан хаагчид, Мэргэжлийн инженер, зөвлөхүүд гэх мэт.*

- *Хэлэлцүүлэгт оролцогчдод тавигдах шаардлагуудыг нарийвчлах. Ялангуяа хэлэлцүүлгийн төгсгөлд санал хураах бол оролцогчдын тэнцвэрийг заавал хангах хэрэгтэй байдаг. Жишээлбэл, аль болох төрийн албан хаагчдын төлөөллийг бусад оролцогдоос бага байлгах... эмзэг бүлгийн төлөөлөл оруулах гэх мэт Сургамж:*

- *... Хэлэлцүүлэгт иргэдийн төлөөлөл хэт бага байгаагаас шалтгаалж иргэдийн хэлэлцүүлэг нь төрийн албан хаагчдын хоорондох хэлэлцүүлэг мэт болж, иргэд шийдвэрт нөлөөлж чадах гүйд хүрэх тохиолдол гарч байв...*

- *... Сургуулийн засварийг санхүүжүүлэх саналыг дэмжихийн тулд сургуулийн удирдлагын төлөөллөөс гадна, иргэдийн төлөөлөл гэсэн нэрийн дор сургуулийн багш нар олноор оролцож санал өгч байсан... /эх үүсвэр: ОНЗДХ төслийн орон нутгийн жилийн тайлангаас /*

Хэлэлцүүлэгт тухайн асуудлаар эрх ашиг нь хөндөгдөж буй талууд оролцогч байна. Жишээлбэл, ядуурлыг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын чиглэлийг хэлэлцэхэд орон нутгийн ядуу болон нэн ядуу иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл түлхүү оролцоно. ОНЗДХ төслийн хувьд хэлэлцүүлэгт оролцогчийн дийлэнхи нь төслийн үр ашгийг хүртэх хүмүүс байдаг. Хэлэлцүүлэгт оролцогчдын бүрэлдэхүүний хувьд төрийн албан хаагчийн төлөөлөлөөс энгийн иргэдийн төлөөлөл илүү байхад анхаардаг байна.



Зураг 3. ОНЗДХ төслийн хэлэлцүүлэгт оролцогчдын бүрэлдэхүүн



В. Хэлэлцүүлгийг зохион байгуулж явуулах.

Зорилго: Хэлэлцүүлэгт оролцогчдын дэвшүүлж болох бүхий л саналуудыг гаргаж, нэгтгэх.

Хэлэлцүүлэг идэвхижүүлэгчийн үүрэг:

- Идэвхижүүлэгч нь хэлэлцүүлгийн явцыг зорилгод чиглүүлэх, оролцогчдын санаа бодлыг бүрэн гаргуулахын тулд тэднийг бүлгээр болон ганцаарчилсан байдлаар зохион байгуулах, гарсан санааг нэг бүрчлэн тэмдэглэж нэгтгэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй ажиллана.

- Хэлэлцүүлэг нь тодорхой зохион байгуулалттай байж үр дүнгээ өгдөг учраас өөрийн гэсэн дүрэмтэй байх ёстой. Хэлэлцүүлэг эхлэхээс өмнө идэвхижүүлэгч нь оролцогчдын тусламжтайгаар дүрэмээ батлах хэрэгтэй байдаг. Гэхдээ дүрмийг аль болох оролцогчдоор өөсдрөөр нь санаачлуулах, батлуулахыг хичээх хэрэгтэй. Дүрэмд дараах зүйлсүүдийг тусгаж болдог:

o Цаг барих, хоцрох

o Хэлэлцүүлгийн явцад гар утас ашиглах эсэх

o Санал хэлэхдээ бусдыг хүндлэх, идэвхижүүлэгчид гар өргөн мэдэгдэх гэх мэт.

Анхаарах зүйлс:

- Идэвхижүүлэгч нь хэлэлцүүлгийн явцад төвийг сахисан байр сууринаас асуудалд хандах ёстой. Аль нэг саналыг илт дэмжих болон буруушаах нь хэлэлцүүлгийн уур амьсгалыг эвддэг.

- Оролцогчдын илэрхийлэхийг хүссэн саналуудыг бүгдийг гаргуулахын тулд “та бүгдэд нэмж асуулт байна уу?” гэсэн асуултыг давтан асуух хэрэгтэй болно.

- Аль болох өөрөө бус оролцогчдоор санал гаргуулахыг хичээх.

- Оролцогчдын дэвшүүлж буй санааг дэлгэц цаасан дээр буулгах аас өмнө ямар нэгэн байдлаар хэлэлцэх, буруу зөвийг нь шүүхгүй байх. Бүх оролцогчдын саналыг авсаны дараа бүгд саналуудаа нэгтгэх, чухал бус, зорилгоос хазайсан саналуудыг хасах алхам хийгдэх тул түр азна.

- Оролцогчдыг багаар ажиллуулах бол оролцогчдын идэвхи, өөрийгөө илэрхийлэх чадвар, аль талын төлөөлөл болох зэргийг нь харгалзан үзэж багуудын тэнцвэрийг хангах.

- Хэлэлцүүлгийн явцад нэг газраа гадас шиг зогсохгүй байх. Ялангуяа бичиж тэмдэглэсэн, зүйлс, оролцогч хэн нэгнийг биеэрээ халхлан удаан зогсох нь тун зохимжгүй байдаг.

Энэ үе шатанд хэлэлцүүлэгт оролцогчид өөрсдийн санаа бодол, хэрэгцээт ажил, үйлчилгээнийхээ чиглэлийг нэгтгэн зөвшилцөж, шийдвэр гаргана. Хэлэлцүүлэгт оролцогч бүрийн санаа, санаачлага өөр байдаг тул хэлэлцүүлгийг тодорхой аргачлалын дагуу идэвхижүүлэгч удирдан явуулах шаардлага гардаг. Иймээс орон нутагт хэлэлцүүлгийг зохион байгуулж, хөтлөн явуулах идэвхижүүлэгчийг сургаж бэлтгэсэн байх нь чухал юм. Орон нутгийн үйлчилгээг төлөвлөх иргэдийн хэлэлцүүлгийг зохион байгуулах асуудал нь нутгийн удирдлагын байгууллага, аймаг, сумын ИТХ, баг, хорооны ИНХ-ын үүрэг юм.

Хэлэлцүүлэг идэвхижүүлэгчийг урьдчилан томилох буюу эсвэл хэлэлцүүлэг хийхээс өмнө олонхийн саналаар сонгоно. Хэлэлцүүлгийн идэвхижүүлэгч нь хэлэлцүүлэг эхлэхээс өмнө иргэдэд хэлэлцүүлгийг явуулж буй зорилго, шийдвэрлэх асуудал, хэлэлцүүлгийг явуулах аргачлалыг танилцуулна. Хэлэлцүүлэг нь үндсэн 3 үе шатаар өрнөнө.

Хэлэлцүүлгийг нээх

Бүх хүмүүсийн саналыг авахын тулд оролцогчид эхлээд тус бүртээ, дараа нь багаар ажиллах эсвэл шууд нийтээр хүн бүр санал гаргах гэх мэт хэлбэрүүдийг ашиглана. Багаар ажиллах хэлбэрийг сонгосон тохиолдолд иргэдийг багаар хуваахдаа баг бүрт эн тэнцүү тооны хүмүүсийг нас, хүйс, нийгмийн төлөөлөл, ажил мэргэжлийн онцлогийг харгалзан хуваарилна. Баг бүрийн саналыг танилцуулах иргэн болон саналыг тэмдэглэх хүн тус бүрийг багийн гишүүдийн саналаар томилно. Баг бүрт асуудлыг хэлэлцэх хугацааг (дунджаар 15-20 минут) олгож багийн гишүүдээр хэлэлцүүлнэ. Багийн гишүүдээс гарсан бүх саналыг буруу зөв гэж шүүхгүйгээр бичиж тэмдэглэнэ. Багийн гишүүдээс өөр санал байгаа эсэхийг лавлан оролцогчид санал нэгдсэн тохиолдолд багийн саналыг тайлбарлах нэг гишүүн гарч ирж нийтэд багийн саналыг танилцуулна. Баг бүрийн танилцуулгын дараа бусдаас нь асуух, тодруулах зүйл байгаа эсэхийг асууна.

Хэлэлцүүлгийг нарийвчлах

Энэ шатанд хэлэлцүүлгээс гарсан саналуудыг хамтран эмхэлж, цэгцлэн шийдвэр гаргахад бэлтгэнэ. Идэвхижүүлэгч нь бүх саналууд танилцуулсны дараа хэлэлцүүлгийн зорилготой нийцээгүй саналыг оролцогчдоор тодорхойлуулан жагсаалтаас хасна.

Жишээлбэл, ОНЗДХ төслийн хэлэлцүүлгээр төслийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосон ажил үйлчилгээний жагсаалтад орсон санал байгаа эсэхийг оролцогчдоор тодорхойлуулж, жагсаалтаас хасна. Ингэхдээ идэвхижүүлэгч зөвхөн бүх иргэд санал нэгдсэн тохиолдолд дараагийн алхамд шилжих бөгөөд хасалт хийсний дараа давхардсан санал байгаа эсэхийг оролцогчдын шийдвэрээр тодорхойлон, давхардсан санал бүрийг тоолж, нэрийн ард дугаарыг тавина. Санал давхардаж байгаа эсэх дээр мөн оролцогчдын саналыг авч, тухайн санал гаргасан хүн, багаас тодруулж байж ижил санаа гэж үзнэ.

Оролцогчдын саналыг тэмдэглэхэд анхаарах зүйлс:

- Саналуудыг нэгтгэх, тэмдэглэхэд идэвхижүүлэгч болон оролцогчдод дэлгэц цаас, өнгийн харандаа(полмастер), наалддаг тууз зэрэг хэрэгтэй болно.

- Оролцогчдыг анхлан дэвшүүлсэн санааг дэлгэц цаасан дээр хар, эсвэл хөх өнгийн үзгээр бичих нь зохимжтой байдаг. Үүний дараа нэмж оруулсан санааг ногоон, хасагдах санааг улаан өнгийн үзгээр тэмдэглэх зэргээр өнгө ялгах нь оролцогчдод ойлгомжтой болгодог.

- Оролцогчдын гаргасан бүх саналуудыг дэлгэц цаасанд буулгасны дараа саналуудыг нэгтгэх, орон нутгийн хариуцан гүйцэтгэж болохгүй ажил, үйлчилгээ байвал жагсаалтаас хасах зэргээр шинэ жагсаалт гаргана.

Хэлэлцүүлгийн шийдвэр гаргах

Энэ үе шат нь хэлэлцүүлгийн асуултад хариулах, хамтын шийдвэрт хүрэх үйл явц юм. Багуудаас гарсан жагсаалтаас хамгийн чухал санаа нь аль болохыг оролцогчдоос асууна. Хамгийн их давтагдсан тоотой саналыг хамгийн чухал санал гэж шууд үзэхгүй, энэ саналтай санаа нийлж байгаа эсэхийг нийт оролцогчдоос асуун, санал нийлэхгүй байгаа иргэн, багийн саналыг өөрсдөөр нь тайлбарлуулна. Бүх оролцогчид хамтаараа нэг санал дээр нэгдэх хүртэл үргэлжилнэ. Санал нэгдсэн хамгийн чухал санааг дэлгэц цаасанд бичнэ. Хэлэлцүүлгээс зөвхөн нэг биш хэд хэдэн чухал санаа гарч болно. ОНЗДХ төслийн хэлэлцүүлгээр хамгийн чухал гэсэн 3 санааг оролцогчид тодорхойлдог байна.

**Г. Хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэж, шийдвэр гаргагчдад хүргүүлэх.**

Зорилго: Хэлэлцүүлгээр гарсан саналыг баримтуулан, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх

Энэ шатанд хэлэлцүүлгээс гарсан нийт саналыг нэгтгэн дүгнэж, тайлан хэлбэрт оруулна. Тайланг хэлэлцүүлгийг зохион байгуулагч нэгтгэх бөгөөд нутгийн удирдлагын байгууллагад хүргэх, тэдний шийдвэрт хэлэлцүүлгийн саналыг тусгах асуудлыг хариуцдаг.

Хэлэлцүүлгийн үр дүнг бүрэн дүүрэн ашиглахад нутгийн удирдлагын байгууллага ялангуяа ИТХ-ийн идэвхи санаачлага, дэмжлэг чухал боловч иргэд, олон нийтийн шууд ба шууд бус оролцоо ч мөн байх ёстой юм. Жишээлбэл, ОНЗДХ төслийн туршилтын аймгуудад аймгийн болон сумын ИТХ-ын төлөөлөгчид нь ОНЗДХ төслийн орон нутгийн менежертэй хамтран сум, багийн хэлэлцүүлгийн дүнг нэгтгэн ИТХ-н хуралдаанд танилцуулан, аймгийн ИТХ нь сум бүрийн хэлэлцүүлгийн дүнг авч үзэн, тухайн сумд хэрэгжүүлэх төслийн чиглэлийг шийдвэрлэдэг байна.

Иргэдийн оролцоот төлөвлөлтийн аргыг орон нутгийн байгууллагаас гадна орон нутгийн төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд аливаа төслийн хэрэгцээг тодорхойлох болон бусад зорилгоор ашиглах боломжтой. Үүнээс гадна уг аргыг доор дурьдсан асуудлыг шийдэхэд амжилттай хэрэглэж буй туршлага байдаг байна. **Үүнд:**

- Ядуурлыг бууруулахад;
 - Орон нутгийн хөрөнгө оруулалтыг зөв зохистой зарцуулахад;
 - Байгалийн нөөцийн зөв зохистой хуваарьлалтын менежмент;
 - Жендер болон хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд;
 - Байгууллагын чадавхийг бэхжүүлэх болон олон нийтийн оролцоог идэвхижүүлэхэд;
 - Засаглал дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах үйл явцыг дэмжих;
 - ДОХ болон БЗХӨ-нөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хандлагыг төлөвшүүлэхэд;
- тус тус ашиглан ашиг тусыг нь хүртэж байна.

Иргэд орон нутгийн үйлчилгээг төлөвлөхөд оролцох хууль эрх зүйн ямар боломж байна вэ?

Монгол Улсын Үндсэн хууль

Арванзургаадугаар зүйл

9. шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.

10. нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.

16. итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.

17.хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

Хорингуравдугаар зүйл

10. Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

Иргэдийн хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэх ажлыг хэлэлцүүлгийн идэвхижүүлэгч нийт иргэдийн саналаар гүйцэтгэнэ. Хэлэлцүүлгийг зохион байгуулагч тал нь хэлэлцүүлгээс гарсан хамгийн чухал саналыг өөрийн үйл ажиллагаагаа төлөвлөхөд ашиглах буюу хамтран ажиллагч болон бусад холбогдох байгууллагад уламжилна.

Холбогдох байгууллага нь өөрийн шийдвэртээ тусгаснаар иргэдийн хэлэлцүүлгийн санал бодит ажил болох боломжтой болдог. Жишээлбэл, ОНЗДХ төслийн сумын хэлэлцүүлгээс гарсан нэн тэргүүний хэрэгцээт гурван саналыг аймгийн ИТХ хэлэлцэн шийдвэрлэж, нэг саналыг төсөл хэлбэрээр тухайн сумд хэрэгжүүлдэг байна.

Хоёрдугаар бүлэг *Иргэдийн оролцоо бүхий хяналт*

Орон нутгийн хэрэгцээт ажил үйлчилгээг төлөвлөхөд иргэд оролцсоноор засаглалд оролцох иргэдийн оролцоо дуусахгүй. Иргэд орон нутгийн үйлчилгээг нийлүүлэх, хөрөнгө оруулалт болон хүрсэн үр дүнг дүгнэн хэлэлцэж болно. Хяналтыг зөвхөн иргэдийн төлөөллийн байгууллага эсвэл мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлэх ёстой гэсэн өрөөсгөл ойлголт хүмүүсийн дунд байдаг. Мөн иргэдийг тухайн төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлын талаар мэргэжлийн мэдлэг дутмаг, ашиглах түүхий эд, материал болон ашиглалтын горимын талаар мэдэхгүй гэж орон нутгийн удирдлагууд өнгөцхөн дүгнэдэг.

Нөгөө талаас иргэд орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтыг зөвхөн үйл ажиллагаа хэрэгжиж дууссаны дараа хэлэлцдэг гэж өрөөсгөл ойлгох хандлага байдаг. Ихэнхи тохиолдолд төсөл, хөтөлбөр хэрэгжсэний дараа гарсан зөрчил дутагдлыг арилгах боломжгүй болсон байдаг. Энэ бүгдээс болж иргэдийн хэрэгцээг хангаагүй үйлчилгээг орон нутгийн байгууллагуудаас үзүүлэх, хэлэлцүүлгээр анхлан дэвшүүлсэн асуудал шийдэгдэхгүй байх явдал гардаг.

2.1 Яагаад иргэдийн оролцоо бүхий хяналт хэрэгтэй вэ?

Иргэд хэлэлцүүлгийн эцэст шийдэх ёстой асуудлаа тодорхойлж, нутгийн удирдлагын байгууллагад уг асуудлыг уламжилна. Гэхдээ чанартай үйлчилгээ ирнэ гэж зүгээр суун, хүлээж байх нь хэр зөв бол. Иргэдийн санал, хүсэлтийн дагуу бариулсан худаг 3 сарын дараа шахуурга нь эвдэрч ажиллахгүй болох, сургуулийн шинэ барилга жилийн дараа өнгө нь гандаж, байгуулсан цэцэрлэгт суух сандалгүй, бариулсан зам тань жилийн дараа цөмөрч муудах зэрэг асуудлууд тулгарч байв уу? Ийм байдал үүсвэл “муу гүйцэтгэж дээ” гэсэн бодол тээгээд өнгөрөхөөс өөр аргагүй байдал үүсдэг. Замаа дахин засах мөнгөгүй болсон, цэцэрлэгт сандалгүй учраас хараад зогсохоос өөр аргагүй, өнгө муутай байшинтай гээд хүүхдүүдээ сургуульд явуулахгүй байх уу.

Энэ бүгдээс харвал хяналт бол дан ганц орон нутагт хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний эцсийн үр дүнг үнэлэж дүгнэхийг хэлэхгүй. Үйл ажиллагааг хэрэгжиж байх явцад үнэлж дүгнэх, засч залруулах болон эцсийн үр дүн иргэдийн хүлээлттэй хэр нийцэж байгааг тодорхойлох нь үр дүнтэй хяналтын үйл ажиллагаа юм.

Хяналт гэж юу вэ?

Хяналт бол төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдаж асуудлуудыг тухай бүр нь илрүүлэн засч залруулах идэвхитэй үйл ажиллагаа юм.

- *Ажлын явц төслийн эцсийн зорилго чиглэлтэй зохицож байгааг харах*
- *Одоогийн гүйцэтгэл нь төлөвлөгөө болон стандарттай нийцэж байгаа эсэхийг шалгах*
- *Үйл ажиллагаа нь зөв дарааллаар явагдаж байгааг хянах*
- *Хэрэв шаардлагатай бол зөвлөгөө өгөх, санал гомдол гаргах, засч залруулах*



Хяналтын үйл ажиллагааг үр өгөөжтэй болгохын тулд төслийн **хэрэгжилтийн явцад, хүрсэн үр дүнг нэгтгэн дүгнэхэд** иргэдийн оролцоо маш чухал юм. Ялангуяа хэрэгжилтийн явцад тавих хяналтанд оролцсоноор иргэд өөрсдийн ойлголт, үнэлэмжтэй болж, идэвхи санаачлага нь ч нэмэгддэг. Мөн төслийн эцсийн зорилготой хэрэгжилтийн явцыг уялдуулахад ч чухал нөлөө үзүүлнэ. Төслийн эцсийн үр дүн, хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээний эцсийн чанарыг иргэдийн хэрэгцээ шаардлагыг хэр хангаж байгаагаар үнэлнэ. Иймд орон нутагт хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалтын эцсийн чанарт үнэлгээг иргэд өгөх ёстой гэдгийг мартаж болохгүй юм.

Санамж:

...Үйлчилгээний чанар эцсийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжаар хэмжигддэг...



Орон нутгийн удирдлагын байгууллагаас үзүүлж буй ажил, үйлчилгээний хяналтанд иргэд оролцсоноор дараах давуу тал болон боломжууд бий болох болно.

Орон нутгийн засаглалын ил тод байдал сайжирна. Иргэд хяналтанд оролцож байх явцад нутгийн удирдлагын байгууллага өөрийн баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж буй хөтөлбөр чиглэлийнхээ мөн чанар, гол санааг таниулах боломж бий болдог. Иргэдийн зүгээс ч нутгийн удирдлагын байгууллагын үзүүлж буй үйлчилгээний мөн чанар, үе шат болон эмх цэгцийн талаар ойлголттой болдог байна. Өөрөөр хэлбэл оролцоо бүхий хяналт нь иргэдэд бодит мэдээллийг түгээдэг.

Иргэдийн идэвхи санаачлага дээшилнэ. Ажил, үйлчилгээг хүргэх үйл ажиллагааны талаар зохих мэдлэг, туршлагатай болсон иргэд дараа дараагийн ажил, үйлчилгээний хяналтанд туршлагажиж, идэвхи санаачлагатай болох болно. Хүлээж суух бус хийж бүтээх ёстой гэсэн ухамсар иргэдэд төлөвшүүлэх нь оролцоог хангах үйл ажиллагааны нэгэн чухал зарчим байх ёстой.

Орон нутгийн засаглалын хариуцлага сайжирна. Бодитой мэдээлэл, мэдлэг бүхий, туршлагажсан иргэд нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналтыг тавьж чадна. Орон нутгийн засаглалын түвшин дэх авилга, хээл хахуулын хэмжээг бууруулахад чухал нөлөөтэй байх болно.

Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөтэй болно. Хэдийгээр ажил, үйлчилгээг гардан гүйцэтгэж байгаа гүйцэтгэгчийн (барилга барьж, зам гүүр засварлаж буй компани, аж ахуйн нэгжүүд) үйл ажиллагаанд орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага, Засаг даргын зүгээс хяналт тавих үүрэгтэй байдаг ч бодит байдал дээр гүйцэтгэлийн явцад тавих хяналт сул байдаг. Энэ хяналтыг иргэдтэй хамтран хэрэгжүүлснээр орон нутгийн удирдлагын байгууллагын зүгээс ч тодорхой хүн хүч, зардал хэмнэх боломж бий юм.

Орон нутгийн ажил, үйлчилгээний чанар сайжирна. Орон нутгийн ажил, үйлчилгээний чанарыг өнгөрсөн хойно нь ярих бус, үйлчилгээг бий болгож, хүргэж байх явцад нь хяналт тавин шалгаж байх хэрэгтэй байдаг. Энэ нь хөрөнгө оруулалтыг үргүй зарахаас сэргийлдэг. Мөн иргэд хяналтын үйл ажиллагаанд оролцсоноор хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон орон нутгийн өмч хөрөнгө, барилга байгууламжаа хайрлан хамгаалах сэтгэл зүйтэй болж, үйлчилгээний төлбөр хураамжаа төлөх ёс зүйтэй болдог.

2.2 Үр дүнтэй хяналт хийх нь

Орон нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг болон зам, гүүр барих, эмнэлгийн тоног төхөөрөмж суурилуулах зэрэг инженерийн нарийн тооцоолол, өндөр стандарт шаардагдах хөрөнгө оруулалтын ажлуудыг иргэдийн оролцоотой үнэлж дүгнэх нь хялбар зүйл биш юм. Гэхдээ хяналтын үйл ажиллагааг нарийн нягт төлөвлөж, иргэдэд зааварчлага дэмжлэг үзүүлж чадвал амжилт олох бүрэн боломж байдаг. Юуны түрүүнд хийх гэж буй үйл ажиллагааныхаа ерөнхий дүр төрх(загвар)-ийг тодорхойлж, үйл ажиллагааны үе шатыг төлөвлөх хэрэгтэй юм. Жишээлбэл, иргэдийн оролцоо бүхий хяналт хэрэгжүүлэх 5 үндсэн алхамыг тодорхойлж болно³.




Олон нийтийн хяналтын зөвлөл байгуулж, зохион байгуулалтанд орох



Олон нийтийн хяналтын зөвлөлийг чадавхижуулах



Төслийн хэрэгжилтэнд хяналт тавих



Үр дүнгээ нэгтгэн боловсруулах



Тайлагнах болон шийдвэр гаргагчдад мэдээлэх

Зураг 4. Хяналтын үйл ажиллагааны ерөнхий загвар

3. Энэ 5 үе шат нь зөвхөн жишээ болгож буй загварын үе шатууд бөгөөд орон нутагт хэрэгжүүлэх ажлын онцлог, хяналт үнэлгээнд оролцогчдын чадавхи зэргээс шалтгаалан ялгаатай тодорхойлогдож болох юм.



Эхний алхам: *Олон нийтийн хяналтын зөвлөл байгуулах болон зохион байгуулалтанд оруулах*

Зорилго: *сайн дурын гишүүдээр баг бүрдүүлж, багийн дотоод харилцааг бий болгож, хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болох*

Энэ шатанд хяналт хийх багийг бүрдүүлж, сайн дурын гишүүдийг урина. Та ганцаараа хяналт хийх бус, эрх ашиг нь хөндөгдөж буй бусад иргэдийг нэгтгэн олон нийтийн хяналтын зөвлөл байгуулж, хяналтыг хийх нь хяналтыг үр дүнтэй болоход нөлөөлнө. Олон нийтийн хяналтын зөвлөлийг (ОНХЗ) та өөрийн санаачлагаар байгуулж болохоос гадна бусад байгууллагаас зохион байгуулж буй ОНХЗ-ийн бүрэлдэхүүнд ч орон ажиллаж болно. Жишээлбэл, ОНЗДХ төслийн санхүүжилтээр хийгдэж буй ажлын гүйцэтгэлд үнэлгээ, дүгнэлт өгөх олон нийтийн хяналтын зөвлөлийн (ОНХЗ) бүрэлдэхүүний багийн ИНХ-аар баталдаг байна. ОНХЗ-ын гишүүдэд тухайн ажил үйлчилгээний үр шимийг хүртэх, төсөл хэрэгжиж буй газарт оршин суугч иргэд багтах бөгөөд уг төслийн хэрэгжилтэнд шууд оролцоогүй орон нутгийн иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл 5 хүн байдаг байна. Гэхдээ тоог зөвхөн үүгээр хязгаарлахгүй аль болох идэвхитэй ажиллах хүмүүсийг бүрдүүлэх нь чухал.

Нэгэнт иргэд бүлгийн зохион байгуулалтад орж, хяналт хийхээр шийдсэн бол үнэлгээг хэрхэн хэрэгжүүлэх арга замаа тодорхойлж, ямар харилцаанд хэрхэн оролцохоо урьдчилан тохирох хэрэгтэй болно. Иргэдийн оролцоо бүхий хяналтыг үр дүнтэй явуулахын тулд ялгаатай ашиг сонирхол бүхий оролцогчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, баг дотроо (дотоод харилцаа) болон төслийн гүйцэтгэгчид, нутгийн удирдлагын байгууллагатай (гадаад харилцаа) хэрхэн харилцахаа шийдэх хэрэгтэй болно.

Анхаарах зүйлс:

ОНХЗ-ийг байгуулахад анхаарах зүйлс.

- *Оролцогчид нь тухайн ажлын гүйцэтгэгчээр давхар ажилладаггүй байх.*
- *Тухайн ажлын үр шимийг хүртэх, аль болох олон ялгаатай бүлгүүдээс төлөөлөл оруулах*
- *Засаглалын байгууллагын төлөөллийг аль болох бага байлгах...*

Хяналтын үйл ажиллагааны гол элементүүд нь зохион байгуулах болон тайлагнах юм. Зохион байгуулалтын болон тайлагнах үйл ажиллагааны “Зүрх” нь харилцаа байдаг. Харилцаанд анхаарах 4 зүйл байна.

- *Бодитой бус тодорхойгүй мэдээлэл өгөхөөс зайлсхий.*
- *Хамтран ажиллаж буй хүмүүсийнхээ үнэт зүйлс, зан төлөв, бодол санааг хүндэтгэн үзэж, ойлгож байх*
- *Дутуу дулимаг харилцсанаас үүдэн гарсан үл ойлголцол, болон эргэлзээтэй зүйлсийг тухай бүр нь шийдэж нэг ойлголтод хүрч байх.*
- *Маши тодорхой байдал, логик дараалал, уялдаа холбоо нь харилцаанд оролцогчийн хамгийн итгэлт нөхөр байх болно.*

ОНХЗ-ийн дотоод харилцаа гэдэгт багийн гишүүдийн дотоод зохион байгуулалтыг ойлгоно. Юуны түрүүнд багийн гишүүдийн өөрсдийн талаарх мэдээлэл болон утасны дугаараа солилцох, уулзалт зохион байгуулах газар, цаг хугацаагаа тохиролцох хэрэгтэй юм. Үүний дараагаар хэн ямар ажлыг хийж гүйцэтгэх болон хариуцлагын асуудлыг төлөвлөнө. Энд багийн дотоод “бяцхан” дүрэм баталж ч болох юм.

Хяналт хийх багийн дараагийн хийх зүйл бол үнэлгээг ямар аргачлалаар хэрхэн хийхээ төлөвлөх асуудал байх болно. Өөрөөр хэлбэл хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалтын төлөвлөгөө гаргах бөгөөд үүнд тухайн ажлын хэрэгжилтийн явцад үнэлгээг хэдэн удаа хийх, ямар нэгэн зөрчил дутагдал илэрвэл хэрхэн шийдвэрлэх, хэнд мэдээлэхээ тодорхойлох юм. Жишээлбэл, Төв аймгийн Эрдэнэ сумд хийж буй худгийн засвар, тоног төхөөрөмж суурилуулах ажилтай ОНХЗ нь хамгийн багадаа 4 удаа танилцах ёстой. Гүйцэтгэлийн явцад ямар нэгэн асуудал илрээгүй бол тухайн төслийн гүйцэтгэлийг хариуцаж буй орон нутгийн төслийн нэгжид(ОНЗДХ-н нэгж, Сумын ИТХ-н ажлын алба гэх мэт) мэдээлнэ.



Зураг 5. Хяналтын зохион байгуулалтын төлөвлөгөөний загвар

Хэрэв хяналтын явцад ямар нэгэн зөрчил, дутагдал илэрвэл барилгыг барьж буй компаний удирдлагад мэдээлэл хүргүүлж, шуурхай шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. Барилгын компаний удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх боломжгүй гэж үзсэн нөхцөлд орон нутгийн төслийн нэгжид мэдээлэл хүргүүлнэ. Уг мэдээллийг төслийн нэгж холбогдох орон нутгийн удирдлагын буюу тухайн үйлчилгээг захиалан гүйцэтгүүлж буй байгууллага (Сумын ИТХ, эсвэл Засаг дарга, аймгийн ИТХ, ОНЗДХ төслийн төв нэгж, Мэргэжлийн хяналтын байгууллага гэх мэт)-д танилцуулах үүрэгтэй байна. Мөн орон нутгийн төслийн нэгж нь гүйцэтгэлийн талаарх шуурхай мэдээллийг олон нийтэд түгээх үүргийг хүлээнэ. Орон нутгийн удирдлагын байгууллага нь ОНХЗ-с төслийн гүйцэтгэлтэй холбоотой ирсэн санал хүсэлтийг шийдвэрлэх үүргийг хүлээнэ гэх мэт...



Хоёр дахь алхам: *Олон нийтийн хяналтын зөвлөлийг чадавхижуулах*

Зорилго: *Иргэдийг хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаарх шаардагдах мэдээллээр хангах болон хяналт хийх аргачлал эзэмшүүлэх*

ОНХЗ нь иргэдийн төлөөллөөс бүрдсэн байх тул тэдэнд хэрэгжиж буй төслийн талаарх мэдээлэл дутмаг, төслийг гүйцэтгэгч байгууллагын технологи (жишээлбэл, Халуун усны барилга барихад мөрдөгдөх угсралтын стандарт, дүрэм журам, материалууд гэх мэт)-ийн талаарх мэдлэг, туршлага дутах, хяналтын маягт бэлтгэх болон нэгтгэн тайлагнах чадвар дутах зэрэг асуудлуудтай зайлшгүй тулгардаг. Иймд тэднийг орон нутгийн удирдлагын байгууллага болон төслийн гүйцэтгэлийг хариуцаж буй байгууллагуудаас чадавхижуулах богино хэмжээний сургалтыг зохион байгуулах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл ОНХЗ-ийн гишүүдэд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын талаарх шаардлагатай мэдээллийг өгөх, хяналтын маягтыг хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгөх, хяналтын тайланг нэгтгэх удирдамж зэргээр хангах ёстой. Чиглүүлэх сургалтыг тухайн ажил үйлчилгээг захиалагч байгууллагын мэргэшсэн зөвлөх зохион байгуулж, хөтлөн явуулбал илүү үр дүнтэй байдаг.

ОНХЗ-н гишүүдийг хяналтанд чиглүүлэх сургалтын гол зорилго нь:

- Төслийн гол мөн чанар, үр дүнгийн хүлээлт болон бусад шаардагдах мэдээллүүдийг өгөх
- Хяналтын гол аргачлалыг ойлгуулах болон сургах. Жишээлбэл, үнэлгээний хуудсийг боловсруулах болон бөглөх зааварчлага, нэгтгэх аргачлал гэх мэт
- Тайлан боловсруулах аргачлал эзэмшүүлэх
- Мэргэжлийн байгууллагын зүгээс гүйцэтгэлтэй холбоотой зөвлөгөө өгөх



Гурав дахь алхам: *Төслийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих*

Зорилго: *төслийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийж, гарсан зөрчил дутагдлыг цаг алдалгүй арилгуулах*

Энэ шат нь хяналтын үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг юм. Үр нөлөө бүхий хяналт нь орон нутагт хэрэгжсэн ажил, үйлчилгээг хүлээн авах үед буюу зөвхөн хэрэгжиж дууссаны дараа ажлын үр дүнг хэлэлцэх асуудлаар хязгаарлагдахгүй.

Хяналтын үйл ажиллагаа нь дараах 3 бүрдэлтэй:

- Ажил эхлэхийн өмнөх хяналт
- Гүйцэтгэлийн явцын хяналт
- Хэрэгжилтийн дараах хяналт

Тухайн ажил эхлэхээс өмнө болон хэрэгжилтийн явцад, мөн тухайн ажил хэрэгжиж дууссаны дараа ч хяналтын үйл ажиллагаа чухал юм. Жишээлбэл, танай сумд хэрэгцээтэй халуун усны барилгыг баригдаж дууссаны дараа газрын зөвшөөрөл байхгүй, цэвдэгтэй газар барьсан нь илэрвэл юу болох вэ? Мөн бэлтгэл ажлыг бүрэн хангаагүйгээс болж барилгын ажлын гүйцэтгэл дундаа тасалдах, хугацаа алдах тохиолдол гарч болох юм. Барилгын явцад хяналт тавиагүйгээс болж барилгын суурийг чанаргүй материалаар барьсан байвал яах вэ?

ОНХЗ-өөс тухайн ажилд тавих хяналтыг үр дүнтэй байлгахын тулд ОНХЗ нь ажлын төлөвлөгөө боловруулж, хэрэгжүүлэх нь зохистой байдаг. Төлөвлөгөөгүй хийсэн үнэлгээ нь үр дүнтэй болохоосоо илүүтэйгээр цаг хугацаа үрсэн бөгөөд гүйцэтгэгчдэд хүндрэл учруулж, ОНХЗ нь үнэлгээний үр дүнгээ нэгтгэхэд хүндрэлтэй болдог. Хяналтын ажлын төлөвлөгөөнд ОНХЗ-н үйл ажиллагааны уялдаа холбоо, дэс дараалал, үйл ажиллагаа бүрт зарцуулагдах нөөцийн төлөвлөлт, үйл ажиллагаа тус бүрийг хариуцах гишүүд болон цаг хугацааны үзүүлэлтүүдийг тусгана. Иргэдийн хувьд ашиглаж болох төлөвлөгөөний загварыг хавсралт 4 -д үзүүлэв.

Загварын дагуу төлөвлөгөө боловсруулахдаа хяналтын үйл ажиллагаа гэсэн багананд ажлыг эхлэхээс өмнө юуг бэлдэх, ямар үе шатаар үнэлэх, хэрэгжилтийн явцад хянах зүйлс юу байх болон хэрэгжилтийн дараах үнэлгээг багцлан тусгах хэрэгтэй. Мөн цаг хугацааны үзүүлэлтийг тусгахдаа тухайн үйл ажиллагаанд зарцуулах хугацаа бус, үнэлгээ бүрэн хийгдэж дууссан байх ёстой хугацааны хязгаарыг тусгах нь зохимжтой байдаг.

ОНХЗ-н хяналтын төлөвлөгөө

Хяналтын үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцагч (ОНХЗ-н гишүүн)	Шаардагдах нөөц, хэрэгслүүд
1. (Өмнөх үйл ажиллагаа)			
- Худалдан авах ажиллагааны хяналт	2011.02.20	(Дорж, Цэрэндулам)	Хяналтын маягт
- Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа	2011.03.15	(Дорж, Пүрэв нар)	Хяналтын маягт
- Хяналт хийх бэлтгэл ажлыг хангах	2011.04.25	(Чүлтэм, Пүрэв нар)	Хяналтын маягт
2. (Гүйцэтгэлийн явц дахь үйл ажиллагаа)			

Хяналтын төлөвлөгөөг боловсруулаад төлөвлөгөөнийхөө дагуу үнэлгээг эхлэнэ. ОНХЗ –ийн гишүүд гүйцэтгэлийн явцыг ажиглаж, эсвэл үйлчилгээг бий болгож байгаа газар дээр нь очих замаар мэдээлэлтэй болдог. Гэтэл бодит байдал дээр ОНХЗ-ийн гишүүд ямар нэгэн зөрчил дутагдал илрүүлсэн бол холбогдох байгууллагад нь зөвхөн амаар мэдээлэх, эсвэл хяналтын эцсийн тайлан бичих болоход ямар нэгэн баримт нотолгоо, мэдээлэл цуглуулаагүй тул хүндрэлтэй тулгарах жишээ нэлээдгүй байдаг. Энэ бүхний гол учир нь хяналтанд ямар арга хэрэгсэл ашиглахаа шийдээгүйтэй холбоотой юм.

Хяналтыг хамгийн үр дүнтэй байлгах хэлбэр бол төслийн хэрэгжилттэй биечлэн, газар дээр нь очиж танилцах явдал байдаг. Энэ нь ОНХЗ-д хамгийн үнэн бодитой мэдээллийг бий болгож өгдөг. Гэвч ОНХЗ-ийн гишүүд нь мэргэжлийн хүмүүс биш учраас тэдэнд ойлгомжгүй, хянахад төвөгтэй зүйлс маш их байдаг. Ийм учраас тэдэнд маш сайн боловсруулсан хяналтын маягт тус болно. Хяналтын маягтыг зааврын дагуу бөглөж, холбогдох зөрчил дутагдлыг маягтад тэмдэглэж, гэрэл зурагаар баталгаажуулан авч байх нь ОНХЗ-ийн гишүүдэд маш чухал зүйл юм. Ингэснээрээ бодит мэдээллийг газар дээр нь баталгаажуулж, тайлан бичихэд ч хялбар болно.

Анхаарах зүйлс:

- Үнэлгээг аль болох гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулахгүйгээр зохион байгуулахыг эрмэлзэх.
- Төслийн хэрэгжилтийн явцтай газар дээр нь очиж танилцах нь бодит мэдээлэлтэй болох гол арга.
- Зураг авч, тэмдэглэл хөтлөх хэрэгтэй.

Дараах зүйлсийг авчирхаа мартаж болохгүй.

- Хяналтын маягт (1-с их хувь)
- Тэмдэглэлийн дэвтэр, үзэг
- Зургийн аппарат, Камерь

Орон нутгийн ажил, үйлчилгээг хэрэгжиж эхлэхээс өмнө үйл ажиллагааг хянах болон гүйцэтгэлийн явцыг хянах, гүйцэтгэлийн дараах хяналтын үйл ажиллагаанд зориулж тус бүрд нь хяналтын хуудсыг бэлтгэсэн байх хэрэгтэй. (ОНЗДХ төслийн хүрээнд ашиглагдах хяналтын хуудасны загварыг хавсралт 5-д үзүүлэв.) Ингэж бэлтгэхдээ мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авч, багаараа хэлэлцэн бэлтгэвэл илүү үр дүнтэй байх болно.

Хяналтын маягт боловсруулахад анхаарах зүйлс:

- Өмнөх болон явцын, дараах гэсэн 3 бүрдэлтэй байх
- Аль болох иргэдэд хялбар байлгах үүднээс хариултыг сонгох, тэмдэглэх боломжтой байлгах.
- Тийм эсвэл үгүй гэсэн тэмдэглэгээ хийх боломжтой байх
- Нэмэлт тайлбар бичих хэсэгтэй байх

Үйл ажиллагааг хэрэгжихээс өмнө бөглөх хяналтын хуудсанд ажил үйлчилгээ хэрэгжихээс өмнө заавал гарсан байх ёстой албан шийдвэрүүд батлагдсан эсэх, бэлтгэл ажилтай холбогдох үйл ажиллагаануудыг тусгадаг. Тухайн ажлын үйл явцыг үнэлэх хяналтын маягтанд гүйцэтгэгчийн зайлшгүй хийх ёстой ажлын тоо хэмжээ, тэдгээртэй холбогдох стандартыг тусгана. Харин хэрэгжилтийн дараах хяналтын хуудсанд ажлын эцсийн үр дүн зорилгод хүрсэн эсэх, иргэдийн хүлээлт, үнэлэмжтэй нийцсэн эсэхийг тодруулах асуултуудыг тусгадаг.



Дөрөв дэх алхам: *Хяналтын үр дүнг нэгтгэн боловсруулах*

Зорилго: *ОНХЗ-ийн гишүүдийн хяналтын үр дүнг нэгтгэх тайлан хэлбэрт оруулах, гарсан зөрчил дутагдлыг баримтжуулах*

Энэ шатанд ОНХЗ нь ажлын эхлэл, гүйцэтгэлийн явц болон ажлыг хүлээн авах үед хийсэн үнэлгээний үр дүнг нэгтгэнэ. Үнэлгээний үр дүнг нэгтгэж, хяналт хийсэн үйл явц бүрийг бодит баримтаар баталгаажуулж, ажил цаг хугацаандаа багтсан эсэх, заагдсан ажил гэрээний дагуу ажлын тоо хэмжээгээр чанартай дууссан эсэхийг дүгнэх боломжтой болно. Үр дүнг нэгтгэхдээ ажлын үйл явц бүр дээр ОНХЗ-ийн гишүүдийн үнэлгээ хийсэн нийт гишүүдийн өгсөн тийм болон үгүй гэсэн хариултуудыг тоолж нийлбэрийг гаргана. Доор хүснэгтэнд ОНЗДХ төслийн төсөл хэрэгжихийн өмнөх шатанд ОНХЗ-ийн хяналтын маягыг нэгтгэсэн байдлыг жишээгээр үзүүлэв:

Хяналтын асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
<i>Үйл ажиллагаа 1: Худалдан авах ажиллагааны талаар</i>			
<i>1.1 Энэ ажил дээр тендер зарласан уу?</i>	3	2	<i>ОНХЗ-ийн 2 гишүүн тендерийг зарлах үед аймагт байсан.</i>
<i>1.2 Гүйцэтгэхээр шалгарсан аж ахуйн нэгж тухай сумд үйл ажиллагаа явуулдаг уу?</i>	5	0	
<i>1.3 Уг аж ахуйн нэгжийг гэрээг гүйцэтгэх чадамжтай гэж үнэлж байна уу?</i>	1	4	<i>Тухайн аж ахуйн нэгж худалдаа үйлчилгээ эрхэлдэг тул барилгын ажлын засварыг гүйцэтгэх чадамжгүй.</i>

Үгүй гэсэн хариултыг өгсөн 2 гишүүн нь тендер зарлах үед сумд байгаагүй гэсэн тайлбар нь тендер зарлагдсан гэдгийг баталж байна.

Гүйцэтгэгч аж ахуйн нэгж тухайн ажлыг гүйцэтгэх чадамжгүй гэсэн хариултыг 4 иргэн өгсөн нь тендерийн гүйцэтгэгчийг тодруулахад үнэлгээний хороо хангалттай ажиллаж чадаагүйг гэрчилж байна.

Дээр үзүүлсэн жишээгээр үйл явц бүрд хийсэн үнэлгээг нэгтгэснээр тухайн ажлыг захиалагч байгууллага, хяналт тавих эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэгч нар тодорхой мэдээлэл авах нөхцөл бүрдэж, ОНХЗ-ийн ажлын үр дүн илэрхий болж байна. ОНХЗ-ийн үр дүнг хяналтын зөвлөлөөс томилогдсон 1 гишүүн эсвэл ОНХЗ-ийн гишүүд бүгдээрээ хэлэлцэн нэгтгэж болно. *(ОНЗДХ төслийн хүрээнд хяналтын хуудсыг нэгтгэх загварыг жишээ болгож хавсралт 6-д үзүүлэв)* Ажлын үйл явц бүрийн дараа дээрх байдлаар хяналтын үр дүнг нэгтгэсний дараа дараах асуултад хариу өгөх замаар, товч тайлан хэлбэрээр үр дүнг бичиж болно. **Үүнд:**

	Асуулт
Цаг хугацааны хувьд	Ажил төлөвлөсөн цаг хугацаандаа гүйцэтгэгдсэн эсэх
Чанарын хувьд	Ажил нь чанарын хувьд шаардлага хангаж буй эсэх
Тоо хэмжээний хувьд	Тухайн ажил гэрээнд заагдсан ажлын тоо хэмжээний дагуу гүйцэтгэгдсэн эсэх



Тав дахь алхам: *Хяналтын үр дүнг тайлагнах, мэдээлэх болон асуудлыг шийдвэрлэх*

Зорилго: *Үнэлгээний үр дүнг тайлагнаж, зөрчил дутагдлыг шуурхай арилгуулах арга хэмжээ авах*

ОНХЗ нь үнэлгээний үр дүнг ажлын үйл явц бүр дээр нэгтгэсний дараа хяналтын тайланг захиалагч байгууллагад хүргүүлэх буюу олон нийтэд танилцуулна. Энд анхаарах зүйл нь хяналтын тайлан нь бодит баримтад түшиглэсэн байх бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэлийн явцад авсан зураг, гүйцэтгэгч байгууллагын тайлбар зэргийг хавсаргаж болно. Жишээлбэл, ОНЗДХ төслийн ОНХЗ нь хяналтын тайланг аймгийн ИТХ болон ОНЗДХ төслийн нэгжид хүргүүлснээр тухайн ажлын гүйцэтгэлд тулгарсан бэрхшээл тодорхой болж, асуудлыг шуурхай шийдэх боломжтой болдог.

Тухайлбал, ОНХЗ-ийн тайланд гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанаас хамааран ажлын гүйцэтгэл удааширсан байна гэсэн дүгнэлт гарсан бол аймгийн ИТХ нь гүйцэтгэгч байгууллагатай хариуцлага тооцох, гүйцэтгэгчийг дахин сонгох ажлыг зохион байгуулах зэргээр яаралтай арга хэмжээ авдаг. Үүний үр дүнд ажил төлөвлөсөн цаг хугацаанд, чанартай дуусах боломжтой болдог байна. ОНХЗ-өөр дамжуулан иргэд та бүхэн хяналт хийж, үр дүнг холбогдох байгууллагад танилцуулснаар тухайн ажил төлөвлөсөн хугацаанд, үр дүнтэй, чанартай болно.

Анхаарах зүйлс:

- *Үнэлгээний үр дүнг хяналтын хуудасны загварын дагуу нэгтгэж дүгнэх (хавсралт 6)*
- *Үнэлгээний явцад гарсан зөрчил дутагдлыг тайланд тусгахдаа бодит мэдээ, зураг, видео бичлэг зэргээр баримтжуулсан байх.*

Ашигласан материалын жагсаалт

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол улсын Үндсэн Хууль. 1992 он.
2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2006 он.
3. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль. 2003 он.
4. Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр төслийн “Хэлэлцүүлгийн удирдамж”, “Төвлөрлийг сааруулах бодлогын туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх удирдамж”

Хоёр. Ном, зохиол

1. Женнифер Риетбергэн Мак-Кракен, “Оролцоо бүхий хөгжлийн төлөвлөлт”, интернэтийн хаяг: http://pgexchange.org/images/toolkits/PGX_F_Participatory%20Development%20Planning.pdf
2. Д.Брадлей, Х.Шнайдер, “Оролцоот төлөвлөлт хийх аргачлал: Гарын авлага”, Ви Эс Оү 2004; интернэтийн хаяг: <http://www.eldis.org/go/topics/resource-guides/participation/participation-in-development/approaches-to-participation&id=44175&type=Document>
3. Атенио Засаглалын сургууль, Говерниент Вотч, “Иргэдийн оролцоо бүхий хяналт: Сургуулийн барилгын засвар”, 2010 он.
4. Нээлттэй Нийгэм Форум, “Хууль хэрхэн бүтдэг вэ? Иргэдэд зориулсан хөтөч”, 2004 он.

Хавсралт

Хавсралт 1.

Хэлэлцүүлгийн тайлан гаргах загвар

Хэлэлцүүлгийн тайланг дараах загвараар баг бүрээр гаргах ба сумын нэгдсэн тайланг нэгтгэн гаргаж төслийн орон нутаг дахь менежерт хүргүүлнэ.

1. Аймаг: _____ 2. Сум: _____ 3. Хэлэлцүүлэг явагдсан огноо: _____

4. Оролцогчдийн судалгаа

Хүснэгт №1

№	Ажил	Нас			Хүйс	
		18-35	36-55	55-аас дээш	Эр	Эм
1	Бизнесийн байгууллагын ажилтан					
2	Хувиараа бизнес эрхлэгч					
3	Төрийн бус байгууллага					
4	Малчин					
5	ИТХ-ын төлөөлөгч					
6	ЗДТГ-ын ажилтан					
7	Төсвийн байгууллагын албан хаагч					
8	Нийт					

5. Тухайн хэлэлцүүлгээс гарсан хамгийн чухал 3 санаа

Хүснэгт №2

№	Хамгийн чухал 3 санаа /эрэмбээр нь жагсаана/	Тодруулга /Тухайн төслийн талаар 2-3 өгүүлбэрт багтаан бичнэ/	Баримжаа төсөв /Төслийн өртөг хэд болох вэ?/
1			
2			
3			

6.Хэлэлцүүлгээс гарсан бусад чухал 2-3 санааг нэмж болно

Хүснэгт №3

№	Чухал санаа /эрэмбээр нь жагсаана/	Тодруулга /Тухайн төслийн талаар 2-3 өгүүлбэрт багтаан бичнэ/	Баримжаа төсөв /Төслийн өртөг хэд болох вэ?/
1			
2			
3			

1. Хэлэлцүүлэгт оролцогч эмэгтэйчүүдийн санал. Хэлэлцүүлгийн явц болох төгсгөлд нь идэвхижүүлэгч эмэгтэйчүүдийн байр суурийг онцгойлон асууж тэмдэглэнэ.

2. Нэмэлт санал асуулга болон ярилцлагын дүнг нэгтгэсэн хавсралт

3. Хэлэлцүүлгийг зохион байгуулах болон хэлэлцүүлгийн явцад гарсан хүндрэлүүд

4. Цаашид анхаарах асуудлууд

5. Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсний дараа сонгогдсон санаа

Хавсралт 2.

*ОНЗДХ төслийн Багийн ИНХ-д зориулсан
хэлэлцүүлгийн удирдамжийн жишээ*

1. Хэлэлцүүлгийн зорилго

Хэлэлцүүлгийн зорилго нь “Орон нутгийн засаглалын дэмжих хөтөлбөр” төслийн хөрөнгөөр аймгуудад хэрэгжүүлж болох иргэдийн хувьд хамгийн ач холбогдолтой байх төслийн санаа, чиглэлийг тодорхойлох явдал юм. Төслийн хэрэгцээг тодорхойлохоос гадна хэлэлцүүлгээр тухайн орон нутагт аймаг, сум, багийн ИТХ, Засаг даргын ТБУСТ хуулийн 52.2-т заасан чиг үүргийн дагуу орон нутагт хүргэх үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох, ирэх оны төсвийн төлөвлөлтөд иргэдээс гаргасан ажил, үйлчилгээний санхүүжилтийг тусгах зорилготой.

2. Хэлэлцүүлэгт оролцогчид

Хэлэлцүүлэгт дараах төлөөллийг бүрэн хангасан байна. Үүнд:

1. Хэлэлцүүлэгт иргэдийн төлөөлөл нийт оролцогчдийн 50% -иас илүү байна. (төрийн албан хаагчдын оролцоо аль болох бага байхаар)
2. Эмэгтэйчүүдийн төлөөлөл нийт оролцогчдийн 50% -иас илүү байна.
3. Бизнесийн байгууллага, хувиараа бизнес эрхлэгчид
4. Малчид
5. Төрийн бус байгууллага, иргэний нийгэмийн байгууллага
6. Аймгийн ИТХ-ын төлөөлөгч
7. Сумын ИТХ-ын төлөөлөгчид
8. Сумын ЗДТГ-ын мэргэжилтэн
9. Төсвийн байгууллагын албан хаагчид
10. Бусад

3. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажил

Иргэдийн нийтийн хуралд оролцогчдод хэлэлцүүлгийн дэг, журмыг танилцуулсан байна. Иргэдэд ОНЗДХ төслийн үйл ажиллагааг товчхон танилцуулна. Төслийн үйл ажиллагааны танилцуулгыг төслийн орон нутаг дахь менежер хэвлэмэл байдлаар хүргүүлсэн байна. Иргэдэд төслийн хөрөнгөөр санхүүжүүлж болохгүй хориглох үйл ажиллагааны чиглэлүүдийг томоор бичиж, хэлэлцүүлгийн явцад ашиглахаар бэлдэнэ.

Орон нутагт аймаг, сум, багийн ИТХ, Засаг даргын ТБУСТ хуулийн 52.2-т заасан чиг үүргийн дагуу орон нутагт хүргэх үйлчилгээний чиглэлийг танилцуулна. Иргэдээс авах саналыг нэгтгэхэд ашиглахаар цаас болон бичгийн хэрэгслийг төслийн орон нутаг дахь менежерээс авч бэлдэнэ. Иргэдээс авах асуулгын хавсралт □ 2-ыг оролцогчдын тоогоор хувиан олшруулна.

4. Хэлэлцүүлгийг зохион байгуулах

- Хэлэлцүүлэгт оролцогчдыг баг, бүлгийн зохион байгуулалтад оруулна (3-4 бүлэг үүсгэнэ).
- Оролцогчдыг баг бүлгээр хувиарлан суулгана.
- Багийг хуваахдаа иргэдийг ажил мэргэжил, нас, бүлэг, нөхөрлөлийн төлөөллийг тэнцүү байдлаар хувиарлана.
- Баг бүлгийн ахлагчдыг томилно. /1-р баг: _____
2-р баг: _____ 3-р баг _____ 4-р баг: _____ гэх мэт/
- Баг бүрт багийн саналыг тэмдэглэх тэмдэглэл хөтлөх хөтлөгч 1 хүн томилогдож ажиллана.

- Баг бүлгүүдийг санал гаргах хугацаа болон бусад нөөцөөр хангаж өгнө. (хэлэлцүүлгээ өрнүүлэх 15- 20 мин) *Үүнд:*

- Аймаг, сум, багийн Иргэдийн хурал, Засаг даргын хариуцах үйлчилгээний хамрах хүрээг нийтэд танилцуулж дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. (тухайн хуулиас авсан лавлагаа материалыг хавсарган тайлбарлах)
- Багийн гишүүн бүрийн адил, тэгш оролцоонд сумын ИТХ-ын төлөөлөгч болон багийн ИНХ-ын тэргүүлэгчидээс хяналт тавьж оролцоог дэмжиж ажиллана.


- Баг бүрийг дарааллын дагуу үр дүнг өөрсдөөр нь танилцуулах (1-2 хүнээр) хэлэлцүүлэх ажиллагаа (5-7 мин) явагдана.

Хэлэлцүүлгийн үндсэн үйл ажиллагааг *хэлэлцүүлэг явуулах аргачлалаар* удирдана.

5. Хэлэлцүүлэг явуулах аргачлал


Хэлэлцүүлэг явуулахдаа аргачлалын хувьд дараах үндсэн гурван үе шат байхыг заавал төлөвлөж ажиллана. I үе шат нь нээх, II үе шат нь нарийвчлах, III үе нь шийдвэр гаргах үе шат юм. Ямар ч хэлэлцүүлэг эдгээр ялгаатай гурван үе шатыг заавал дамжин явагдана. Цэгцтэй, зөв хэлэлцүүлэг явуулахад энэ 3 үе шатыг дагах шаардлагатай.


Доорх дүрсийг харвал хэлэлцүүлэг эхлээд нэлээд задгай, өргөн цартай эхлээд цаашид системтэйгээр хумигдаж эцсийн шийдвэр гаргахад чиглэгдэх ёстойг харуулж байна.



1.Нээх 2.Нарийвчлах 3.Шийдвэр гаргах

Идэвхижүүлэгч нь нэг үе шат бүрэн хийгдэж дууссаны дараа дараагийн үе шатанд орох ба дууссан үе шат руу эргэж хэзээ ч ордоггүй болохыг чанд сахиж ажиллана.

Үе шат	Зорилго	Хийгдэх үйл ажиллагаа
 <p data-bbox="168 586 223 616">I үе</p> <p data-bbox="168 662 223 693">Нээх</p>	<p data-bbox="306 535 580 734">Оролцогчдоос хамгийн хэлэцж буй асуудлыг тухай бүх санааг олж авах явдал юм.</p>	<ul style="list-style-type: none"> <li data-bbox="602 258 1204 415">- Хэлэлцүүлгийн эцэст гарсан байх шийдвэр, үр дүнг танилцуулж дэлгэц цаасанд гарчиглан бичнэ. (Жишээлбэл, ОНЗДХ-өөс хэрэгжүүлж болох хамгийн чухал төслийн 3 санааг гаргах) <li data-bbox="602 430 1126 502">- Ганцаар эсвэл багаар хувааж асуултыг тавьж оюуны довтолгоо хийнэ. <li data-bbox="602 517 1139 586">- Аль болох гарч болох бүх саналыг авахыг хичээнэ. <li data-bbox="602 601 1110 632">- Саналыг буруу зөв байна гэж шүүхгүй <li data-bbox="602 647 1180 715">- Дэлгэц цаас эсвэл Idea картан дээр саналыг бичиж авна. <li data-bbox="602 731 1153 799">- Бүх саналыг тэдний өмнө хананд бичиж харуулаад 3-4 минут унших боломж олгоно <li data-bbox="602 814 1177 883">- Жагсаалтад ороогүй нэмэх санал байна уу? Гэж оролцогчдоос асууна <li data-bbox="602 898 1083 967">- Багаас нэг хүн гарч ирж саналуудаа танилцуулна. <li data-bbox="602 982 1174 1051">- Баг бүрийн танилцуулгын дараа бусдаас нь асуух, тодруулах зүйл байгаа эсэхийг асууна.
 <p data-bbox="168 1393 223 1424">II үе</p> <p data-bbox="118 1469 274 1500">Нарийвчлах</p>	<p data-bbox="306 1328 567 1528">Гарсан саналуудыг хамтран эмхэлж, цэгцлэн шийдвэр гаргахад бэлтгэх явдал юм.</p>	<ul style="list-style-type: none"> <li data-bbox="602 1115 1174 1271">- Бүх саналууд танилцуулсны дараа төслийн хориглох зүйлд заасан санал байгааг оролцогчдоор тодрхойлуулж, жагсаалтаас хасна. <li data-bbox="602 1287 1206 1355">- Идэвхижүүлэгч бүр оролцогчид санал нэгдсэн тохиолдолд ямар нэгэн үйлдэл хийнэ. Байнга тэдний заавраар ажиллана. Өөрөө шүүхгүй <li data-bbox="602 1370 1196 1439">- Харин зөвшөөрөгдөх чиглэлээс илт зөрүүтэй зүйлийг өөрөө тайлбарлаж чиглүүлнэ. <li data-bbox="602 1454 1212 1523">- Хасалт хийсний дараа давхардсан саналуудыг тоолж нэрийн ард тоог нь тавина. Үүнийг мөн л оролцогчдын хамтын шийдвэрээр хийнэ. <li data-bbox="602 1538 1147 1606">- Гэхдээ шууд товчлох хураангуйлахыг бүү хичээ, тухайн санал гаргасан хүн, багаас тодруулж байж ижил санаа гэж үзнэ.

 <p>Ш үе Шийдвэр гаргах</p>	<p>Хэлэлцүүлгийн асуулганд хариулах, хамтын шийдвэрт хүрэх явдал юм.</p>	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцүүлгийн асуултыг гарчигт нь бичсэн шинэ дэлгэц цаасыг оролцогчдын өмнө тавина. - Багуудаас гарсан жагсаалтаас хамгийн чухал төсөл нь аль нь болохыг оролцогчдоос асууна. - Ингэхдээ хамгийн их давтагдсан тоотой санааг шууд авахгүй - Магадгүй өөр бусад нь илүү чухал байж болно. Тийм бол тэр үндэслэлийг нь санал гаргасан баг, хүнээр яриулна. - Бүх оролцогчид хамтаараа нэг санал дээр нэгдэх хүртэл үргэлжилнэ. - Идэвхижүүлэгч бүгд санал нэгтэй байна уу гэж байнга асууна. - Санал нэгдсэн хамгийн чухал санааг шинэ дэлгэц цаасанд бичнэ. - Хоёрдогч ба гуравдагч чухал санааг гаргахдаа дээрх процессыг давтана. - Бүгд хамтын зөвшилцөлөөр явагдах ба хэрэв ингэж чадахгүй зөрчил маргаанд хүрвэл санал хураалт явуулна. - Санал хураалтыг явуулахдаа жагсаалтад байгаа бүх санааг тоолно. N- санаа - Нийт санааг 5-д хувааж нэг оролцогчийн өгөх саналыг тооцно. N/5 - 15 санаа жагсаалтад байгаа нөхцөлд нэг хүн 3-н санал өгөх эрхтэй. 3 удаа гар өргөнө. - Оролцогчид сонголтоо хийх цаг өгнө. - Идэвхижүүлэгч санаа тус бүрийг эхнээс нь уншиж оролцогчдоор гар өргүүлэн тоолж тоог нь ард нь бичнэ. - хамгийн олон санал өгсөн санааг 2 эсвэл 3 дагч чухал санаагаар тодруулан нөгөө дэлгэц цаасанд бичнэ.
---	---	--

6. Хэлэлцүүлгийн нэгдсэн дүнг хүргүүлэх

Хэлэлцүүлгээс хамгийн их санал авсан санаануудыг нэгтгэн нэгдсэн дүнг хавсралт №3-д заасны дагуу нэгтгэн бичиж, төслийн орон нутаг дахь менежерт хүргүүлнэ. Хэлэлцүүлэгт оролцогч эмэгтэйчүүдийн гаргасан санал, хэлэлцүүлгийг зохион байгуулах болон хэлэлцүүлгийн явцад гарсан хүндрэл, цаашид анхаарах асуудлуудыг тусгайлан үзэж хавсралт №3-д дүгнэлт байдлаар бичнэ.

Хавсралт 3.*ОНЗДХ төслийн хэлэлцүүлгийн явцад иргэдээс авах асуулгын загвар*

Уг асуулгыг НҮБХХ ба ЗГХЭГ-ын хамтран хэрэгжүүлж буй “Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр” төслөөс явуулж байна. Асуулгын зорилго нь уг төслөөс танай сумд хэрэгжүүлж болох төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох явдал юм.

1. Аймаг: _____ 2. Сум: _____ 3. Хүйс: А.эр Б.эм

4. Нас А.18-35 Б.36-55 В.55-аас дээш

5. Ажил эрхлэлт

А. Бизнесийн байгууллагын ажилтан

Д. Малчин

Б. Төрийн бус байгууллага

Е. ИТХ-ын төлөөлөгч

В. Хувиараа бизнес эрхлэгч

Ё. ИТХ-ын төлөөлөгч

Г. Төрийн бус байгууллага

Ж. ЗДТГ-ын ажилтан

З. Төсвийн байгууллагын албан хаагч

6. Та доорх чиглэлүүдээс танай сум, багт хэрэгжүүлэх шаардлагатай хамгийн чухал төслүүдийг тодорхойлж 3-г сонгоно уу? Чиглэл, салбарын өмнөх дугаараас гуравыг дугуйлж, арын баганад төслийн санааг тодорхой бичнэ үү?

№	Чиглэл, салбар	Хэрэгжүүлж болох төслийн гол санаа, агуулга
1	Ядуурлыг бууруулах, эдийн засгийн хөгжил, түүний дэд бүтцийг дэмжих	
2	Байгаль орчиныг хамгаалах	
3	Нийгмийн хөгжил, орчны тохижилт	
4	Усан хангамжийг сайжруулах төсөл	
5	Нийтийн эрүүл ахуйн үйлчилгээ	
6	Хүн амын боловсролыг дээшлүүлэх	
7	Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах	
8	Орон нутгийн зам, гүүр, нийтийн тээврийг сайжруулах	
9	Хөдөө аж ахуйг дэмжих	
10	Бусад	

Таны нэмэх санал: _____

Огноо: _____ Танд баярлалаа.

Хавсралт 4.

ОНХЗ-н үйл ажиллагааны төлөвлөгөө хийх загвар

№	Хяналтын үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцагч (ОНХЗ-н гишүүн)	Шаардагдах нөөц, хэрэгслүүд
1	(Өмнөх үйл ажиллагаа) - - -			
2	(Гүйцэтгэлийн явц дахь үйл ажиллагаа) - - -			
3	(Хэрэгжилтийн дараах үйл ажиллагаа) - - -			
4	Эцсийн тайлан, танилцуулах			

Хавсралт 5.

*Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүний
хяналтын маягтын загвар*

Орон Нутгийн Засаглалыг Дэмжих Хөтөлбөр төсөл Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүний хяналтын маягт

Ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжиж буй аймаг: _____

Сум: _____

Төслийн нэр: _____

Гүйцэтгэгч байгууллага: _____

Хугацаа: _____

Гэрээний үнийн дүн: _____

Хяналтын зөвлөлийн гишүүний нэр: _____

Утасны дугаар: _____

Оршин суугаа хаяг: _____

Төсөл хэрэгжихийн өмнө бөглөх хяналтын маягт А

Хяналтын асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
Үйл ажиллагаа 1: Худалдан авах ажиллагааны талаар			
1.1 Энэ ажил дээр тендер зарласан уу?			
1.2 Гүйцэтгэхээр шалгарсан аж ахуйн нэгж тухай сумд үйл ажиллагаа явуулдаг уу?			
1.3 Уг аж ахуйн нэгжийг гэрээг гүйцэтгэх чадамжтай гэж үнэлж байна уу?			
Үйл ажиллагаа 2: Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа			
2.1 Хяналтын зөвлөлийн гишүүд хэдэн удаа уулзахаар тохирсон бэ? (<i>Аль нэгийг нь сонгоно уу.</i>)	<input type="checkbox"/> 1 удаа <input type="checkbox"/> 2 удаа <input type="checkbox"/> 3 удаа <input type="checkbox"/> 3-с дээш удаа		
2.2 Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн нийгмийн бүх төлөөллийг хангаж чадсан уу?			
2.3 Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл энэ удаагийн уулзалтад ирсэн үү?			
2.4 Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөллийг хяналт хийх бүрдээ байлгахгаар тохиролцсон уу?			
2.5 Орон нутгийн удирдлагаас та бүхний үйл ажиллагааг дэмжиж байгаа юу?			
Үйл ажиллагаа 3: Хяналт хийх бэлтгэл ажлыг хангасан талаар			
3.1 Танд гүйцэтгэгч байгууллагатай хийсэн ажил гүйцэтгэх гэрээний хуулбарыг сумын удирдлага өгсөн үү?			
3.2 Ажил гүйцэтгэх гэрээний хавсралт болох ажлын тоо хэмжээг тодорхойлсон баримтын хуулбар өгсөн үү?			
3.3 Тухайн ажлын төсөв мэргэшсэн төсөвчнөөр баталгаажсан байна уу?			
3.4 Дээрх баримтыг авахад танд бэрхшээл тохиолдсон уу?			<i>Тийм бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>

Хяналт хийсэн он сар өдөр: _____

Хяналт хийсэн ОНХЗ-ийн гишүүний гарын үсэг _____

Төсөл хэрэгжиж байх явцад бөглөх хяналтын маягт Б

Хяналтын асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
Үйл ажиллагаа 1: Төслийн явцын талаар			
1.1 Төслийн ажил төлөвлөсөн хугацаанд эхэлсэн эсэх			<i>Үгүй бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>
1.2 Төслийн гүйцэтгэл төлөвлөсөн хугацаанд явагдсан эсэх			<i>Үгүй бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>
1.3 Төслийн гүйцэтгэлийн явц шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> Чанарын шаардлага хангасан <input type="checkbox"/> Чанарын шаардлага хангаагүй (Энэ хариултыг сонгосон бол яагаад гэдгийг тайлбарлана уу.)		
1.4 Гүйцэтгэж буй ажил ажлын тоо хэмжээний дагуу хийгдэж байгаа эсэх			<i>Үгүй бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>
1.5 Төслийн гүйцэтгэл удаашралтай байгаа бол та юунаас шалтгаалсан байна гэж үзэж байна вэ?	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> Аж ахуйн нэгжийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас <input type="checkbox"/> Төслийн санхүүжилт удааширснаас <input type="checkbox"/> Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанаас <input type="checkbox"/> Бусад шалтгаан (Тайлбарыг бичнэ үү.)		
Үйл ажиллагаа 2: Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа			
2.1 ОНХЗ гишүүд бүгд төслийн явцад хяналт тавихад оролцсон уу?			<i>Үгүй бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>
2.2 Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл энэ удаагийн уулзалтад ирсэн үү?			
2.3 Төслийн гүйцэтгэлийн явцад хяналт хийсний дараа илэрсэн зөрчил дутагдал	<i>Зөрчил бүрийг нэг бүрчлэн бичнэ үү.</i>		
2.4 Илэрсэн зөрчил дутагдлыг хаашаа хүргүүлсэн бэ?	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> Сумын ИТХ, ЗДТГ-т <input type="checkbox"/> ОНЗДХ төслийн орон нутаг дахь менежерт <input type="checkbox"/> Аймгийн ИТХ, ЗДТГ-т <input type="checkbox"/> ОНЗДХ төслийн төв нэгжид		

Хяналт хийсэн он сар өдөр: _____

Хяналт хийсэн ОНХЗ-ийн гишүүний гарын үсэг _____

Төсөл хэрэгжиж дууссаны дараа бөглөх хяналтын маягт В

Хяналтын асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
Үйл ажиллагаа 1: Төслийн гүйцэтгэлийн талаар			
1.1 Төслийн ажил төлөвлөсөн хугацаанд дууссан эсэх			<i>Үгүй бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>
1.2 Төслийн ажил одоог хүртэл дуусаагүй бол юунаас шалтгаалсан гэж та үзэж байна вэ?	<input type="checkbox"/> Аж ахуйн нэгжийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас <input type="checkbox"/> Төслийн санхүүжилт удааширснаас <input type="checkbox"/> Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанаас Бусад шалтгаан (Тайлбарыг бичнэ үү.)		
1.2 Төслийн гүйцэтгэл шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/> Чанарын шаардлага хангасан <input type="checkbox"/> Чанарын шаардлага хангаагүй (Энэ хариултыг сонгосон бол яагаад гэдгийг тайлбарлана уу.)		
1.4 Гүйцэтгэсэн ажил ажлын тоо хэмжээний дагуу хийгдсэн үү?			<i>Үгүй бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>
1.5 ОНХЗ-өөс илрүүлсэн алдаа дутагдлыг засах талаар гүйцэтгэгч аж ахуйн нэгж ажилласан эсэх			
Үйл ажиллагаа 2: Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа			
2.1 Та төслийг хүлээж авахад бэлэн гэж үзэж байна уу?			<i>Үгүй бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>

Хяналт хийсэн он сар өдөр: _____

Хяналт хийсэн ОНХЗ-ийн гишүүний гарын үсэг _____

Хавсралт 6.

ОНХЗ гишүүдийн хяналтын маягтыг нэгтгэх загвар

***Орон Нутгийн Засаглалыг Дэмжих Хөтөлбөр төсөл**
Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийн хяналтын
нэгдсэн тайлангийн маягт*

Ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжиж буй аймаг: _____

Сум: _____

Төслийн нэр: _____

Гүйцэтгэгч байгууллага: _____

Хугацаа: _____

Гэрээний үнийн дүн: _____

Хяналтын зөвлөлийн гишүүдийн нэрс, утасны дугаар:

1. _____
2. _____
3. _____
4. _____
5. _____

Төсөл хэрэгжихийн өмнөх шатанд ОНХЗ-ийн гишүүдийн хийсэн хяналтын нэгтгэл маягт Г

Хяналтын асуултууд	Тийм гэсэн хариулт өгсөн хүний тоо	Үгүй гэсэн хариулт өгсөн хүний тоо	Тайлбар
Үйл ажиллагаа 1: Худалдан авах ажиллагааны талаар			
1.1 Энэ ажил дээр тендер зарласан уу?			
1.2 Гүйцэтгэхээр шалгарсан аж ахуйн нэгж тухай сумд үйл ажиллагаа явуулдаг уу?			
1.3 Уг аж ахуйн нэгжийг гэрээг гүйцэтгэх чадамжтай гэж үнэлж байна уу?			
Үйл ажиллагаа 2: Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа			
2.1 Хяналтын зөвлөлийн гишүүд хэдэн удаа уулзахаар тохирсон бэ? (<i>Аль нэгийг нь сонгоно уу.</i>)	<input type="checkbox"/> 1 удаа <input type="checkbox"/> 2 удаа <input type="checkbox"/> 3 удаа <input type="checkbox"/> 3-с дээш удаа (Хариулт бүрийн ард давтагдсан тоог тавина) Жишээлбэл, 1 удаа гэсэн хариултын ард 2 хүн гэх мэт.		
2.2 Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн нийгмийн бүх төлөөллийг хангаж чадсан уу?	<i>Тийм гэсэн хариулт өгсөн хүний тоо</i>	<i>Үгүй гэсэн хариулт өгсөн хүний тоо</i>	
2.3 Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл энэ удаагийн уулзалтад ирсэн үү?			
2.4 Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөллийг хяналт хийх бүрдээ байлгахад тохиролцсон уу?			
2.5 Орон нутгийн удирдлагаас та бүхний үйл ажиллагааг дэмжиж байгаа юу?			
Үйл ажиллагаа 3: Хяналт хийх бэлтгэл ажлыг хангасан талаар			
3.1 Танд гүйцэтгэгч байгууллагатай хийсэн ажил гүйцэтгэх гэрээний хуулбарыг сумын удирдлага өгсөн үү?			
3.2 Ажил гүйцэтгэх гэрээний хавсралт болох ажлын тоо хэмжээг тодорхойлсон баримтын хуулбар өгсөн үү?			
3.3 Тухайн ажлын төсөв мэргэшсэн төсөвчнөөр баталгаажсан байна уу?			
3.4 Дээрх баримтыг авахад танд бэрхшээл тохиолдсон уу?			<i>Тийм бол яагаад гэсэн тайлбарыг энд бичнэ үү.</i>

Хяналт хийсэн он сар өдөр: _____

Хяналт хийсэн ОНХЗ-ийн гишүүний гарын үсэг _____

Хавсаргах материалын жагсаалт:

1. ОНХЗ-ийн гишүүн тус бүрийн бөглөсөн төсөл хэрэгжихээс өмнөх үеийн хяналтын маягт А;
2. Төсөл хэрэгжихээс өмнөх үеийн ОНХЗ-ийн гишүүдийн хийсэн хяналтын маягтын нэгтгэл Г;
3. Төсөл хэрэгжихээс өмнөх үеийн байдал, зургаар баталгаажих
4. Гэрээний хуулбар, ажлын тоо хэмжээ
5. Хяналтын зөвлөлийн гишүүдийн төсөл хэрэгжихээс өмнө байдалд хяналт хийсэн товч тайлан

Хариултыг нэгтгэсний дараа төсөл хэрэгжихийн өмнөх шатны хяналтын товч тайланд дараах зүйлүүдийг тусгана. *Үүнд:*

Тендер хуулийн дагуу зарлагдсан эсэх, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн тухайн ажлыг гүйцэтгэх чадавхийн байдал, ОНХЗ-ийн гишүүдийн нийгмийн төлөөллийг хангасан байдал, хяналтын зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, хяналт хийх давтамж, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөллийг хангасан эсэх, орон нутгийн удирдлагын дэмжлэг, ажлын гэрээ, ажлын тоо хэмжээ, мэргэшсэн төсөвчин ажлын төсвийг баталсан эсэх, дээрх баримтуудыг авахад ОНХЗ-д бэрхшээл учирсан эсэх зэргийг хяналтын маягтад гишүүн тус бүрийн өгсөн тийм болон үгүй гэсэн хариултыг нэгтгэсэн тоог үндэслэн бичнэ.

Хяналтын тайланг хургүүлэх: Сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, Аймгийн ИТХ-ын ажлын алба, ОНЗДХ төслийн аймгийн нэгж, ОНЗДХ төслийн төв нэгж

Төсөл хэрэгжих шатанд бөглөх ОНХЗ-ийн гишүүдийн хяналтын нэгтгэлийн нэгтгэл маягт Д

Хяналтын асуултууд	Тийм гэсэн хариулт өгсөн хүний тоо	Үгүй гэсэн хариулт өгсөн хүний тоо	Тайлбар
Үйл ажиллагаа 1: Төслийн явцын талаар			
1.1 Төслийн ажил төлөвлөсөн хугацаанд эхэлсэн эсэх			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
1.2 Төслийн гүйцэтгэл төлөвлөсөн хугацаанд явагдсан эсэх			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
1.3 Төслийн гүйцэтгэлийн явц шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/> Чанарын шаардлага хангасан (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Чанарын шаардлага хангаагүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тоо, (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо, хураангуйлсан тайлбарын хамт</i>)		
1.4 Гүйцэтгэсэн ажил ажлын тоо хэмжээний дагуу хийгдэж байгаа эсэх			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
1.5 Төслийн гүйцэтгэл удаашралтай байгаа бол та юунаас шалтгаалсан байна гэж үзэж байна вэ?	<input type="checkbox"/> Аж ахуйн нэгжийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Төслийн санхүүжилт удааширснаас (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанаас (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Бусад шалтгаан (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>)		
Үйл ажиллагаа 2: Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа			
2.1 ОНХЗ гишүүд бүгд төслийн явцад хяналт тавихад оролцсон уу?			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
2.2 Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл энэ удаагийн уулзалтад ирсэн үү?			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
2.3 Төслийн гүйцэтгэлийн явцад хяналт хийсний дараа илэрсэн зөрчил дутагдал	<i>Зөрчил бүрийг нэг бүрчлэн бичнэ үү. Гишүүн бүрийн бичсэн зөрчил дутагдлыг нэгтгэн бичнэ.</i>		
2.4 Илэрсэн зөрчил дутагдлыг хаашаа хүргүүлсэн бэ?	<input type="checkbox"/> Сумын ИТХ, ЗДТГ-т (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> ОНЗДХ төслийн орон нутаг дахь менежерт (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Аймгийн ИТХ, ЗДТГ-т (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> ОНЗДХ төслийн төв нэгжид (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>)		

Хяналт хийсэн он сар өдөр: _____

Хяналт хийсэн ОНХЗ-ийн гишүүний гарын үсэг _____

Хавсаргах материалын жагсаалт:

1. ОНХЗ-ийн гишүүн тус бүрийн төсөл хэрэгжих явцад бөглөсөн хяналтын маягт Б;
2. Төсөл хэрэгжих шатанд бөглөсөн ОНХЗ-ийн гишүүдийн хяналтын нэгтгэлийн нэгтгэл маягт Д;
3. Төсөл хэрэгжиж байх үеийн байдал, зургаар баталгаажих
4. Хяналтын зөвлөлийн гишүүдийн төсөл хэрэгжиж байх явцад хяналт хийсэн товч тайлан (Маягт Д дээр үндэслэн бичих)

Хариултыг нэгтгэсний дараа төсөл хэрэгжиж буй явцын хяналтын товч тайланд дараах зүйлүүдийг тусгана. *Үүнд:*

Төслийн ажил төлөвлөсөн хугацаанд эхэлсэн болон явагдаж буй эсэх, төслийн гүйцэтгэл нь чанарын шаардлага хангаж буй эсэх, гүйцэтгэсэн ажил нь ажлын тоо хэмжээний дагуу хийгдсэн эсэх, төслийн явц удаашралтай байгаа бол үүний шалтгаан, хяналтын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар бичнэ.

Хяналтын тайланг хүргүүлэх: Сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, Аймгийн ИТХ-ын ажлын алба, ОНЗДХ төслийн аймгийн нэгж, ОНЗДХ төслийн төв нэгж

Төсөл хэрэгжиж дууссаны дараа бөглөх ОНХЗ-ийн гишүүдийн хяналтын нэгтгэлийн нэгтгэл маягт Е

Хяналтын асуултууд	Тийм гэсэн хариулт өгсөн хүний тоо	Үгүй гэсэн хариулт өгсөн хүний тоо	Тайлбар
Үйл ажиллагаа 1: Төслийн гүйцэтгэлийн талаар			
1.1 Төслийн ажил төлөвлөсөн хугацаанд дууссан эсэх			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
1.2 Төслийн ажил одоог хүртэл дуусаагүй бол юунаас шалтгаалсан гэж та үзэж байна вэ?	<input type="checkbox"/> Аж ахуйн нэгжийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Төслийн санхүүжилт удааширнаас (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанаас (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Бусад шалтгаан (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>)		
1.2 Төслийн гүйцэтгэл шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/> Чанарын шаардлага хангасан (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо</i>) <input type="checkbox"/> Чанарын шаардлага хангаагүй (<i>хариулт өгсөн гишүүдийн тоо, товч тайлбарын хураангуй</i>)		
1.4 Гүйцэтгэсэн ажил ажлын тоо хэмжээний дагуу хийгдсэн үү?			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
1.5 ОНХЗ-өөс илрүүлсэн алдаа дутагдлыг засах талаар гүйцэтгэгч аж ахуйн нэгж ажилласан эсэх			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>
Үйл ажиллагаа 2: Олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа			
2.1 Та төслийг хүлээж авахад бэлэн гэж үзэж байна уу?			<i>Үгүй гэсэн хариулт өгсөн гишүүдийн тайлбарын хураангуй</i>

Хяналт хийсэн он сар өдөр: _____

Хяналт хийсэн ОНХЗ-ийн гишүүний гарын үсэг _____

Хавсаргах материалын жагсаалт:

1. ОНХЗ-ийн гишүүн тус бүрийн төсөл хэрэгжиж дууссаны дараа бөглөсөн хяналтын маягт В;
2. Төсөл хэрэгжиж дууссаны дараа бөглөсөн ОНХЗ-ийн гишүүдийн хяналтын нэгтгэлийн нэгтгэл маягт Е;
3. Төсөл хэрэгжсний дараах үеийн байдал, зургаар баталгаажих
4. Хяналтын зөвлөлийн гишүүдийн төсөл хэрэгжсний дараах байдалд хяналт хийсэн товч тайлангийн хураангуй (Маягт Е дээр үндэслэн бичих)

Хариултыг нэгтгэсний дараа төсөл хэрэгжсний дараах байдалд хяналт хийсэн товч тайланд дараах зүйлүүдийг тусгана. *Үүнд:*

Төслийн ажил төлөвлөсөн хугацаанд дууссан эсэх, төслийн ажил дуусаагүй бол түүний шалтгаан, төслийн гүйцэтгэл шаардлага хангаж буй эсэх, гүйцэтгэсэн ажил нь ажлын тоо хэмжээний дагуу эсэх, ОНХЗ-ийн тавьсан шаардлагыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаандаа тусгаж ажилласан эсэх, төслийг эцсийн байдлаар хүлээн авах боломжтой эсэх талаар бичнэ.

Хяналтын тайланг хүргүүлэх: Сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, Аймгийн ИТХ-ын ажлын алба, ОНЗДХ төслийн аймгийн нэгж, ОНЗДХ төслийн төв нэгж

Улаанбаатар хот
2011 он